

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-45
1. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	8-19
2. Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлт	19-35
3. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./	15-45

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
06 дугаар сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 54 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: П.Мөнхтулга;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Т.Аубакир, Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн, Б.Мөнхсоёл, Ч.Номин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Батсуурь, Ж.Ганбаатар.

Нэг.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Н.Наранбаатар, Ж.Батжаргал, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, Байнгын хорооны дарга Н.Наранбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Б.Түвшин, П.Сайнзориг, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Ж.Золжаргал, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Н.Наранбаатар: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орлуулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	9
Бүгд:	18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: Горимын санал дэмжигдсэн тул Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орлуулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын менежер Ц.Хосжаргал, мөн газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, Гүйцэтгэлийн аудитын газрын Өгөгдлийн шинжилгээний ахлах аудитор С.Оюун-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч Ч.Мөнхбаатар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн мэргэжилтэн Т.Мөнхбат,

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын Дэд бүтцийн хэлтсийн дарга Э.Батболд, Монголын Хуульчдын холбооны хуульч Б.Энхчимэг, Архитектор З.Туяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал, С.Төрмөнх, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Д.Мөнхтуяа нар байлцав.

Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Б.Түвшин, П.Сайнзориг, Х.Булгантуяа, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Байнгын хорооны дарга Н.Наранбаатар нар хариулж, тайлбар хийв.

Н.Наранбаатар: Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголын тайланг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	9
Бүгд:	20

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаарх ерөнхий хяналтын сонсголын тайланг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул холбогдуулан боловсруулсан “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Да.Цогтбаатар, Ж.Батжаргал, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэрэгжүүлэх” гэсний дараа “, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэхийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	9

Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, төслийн 1 дэх заалтын “Г” дэд заалтын “зааг ялгаа” гэсний дараа “зохистой харьцаа бий болгох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай гурав дахь дэд заалт нэмэх:

“Гурав.Орон нутгийн төсвийн хувьд хөрөнгө санхүүжилт босгох томоохон төсөл хэрэгжүүлэх дээд хязгаарыг хүн ам, газар нутаг, тухайн орон нутгийн төсвийн орлогыг харгалзан тогтоож өгөхийг Засгийн газарт үүрэг болгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, орон нутгийн бонд гаргахдаа тухайн орон нутгийн эдийн засаг, төсвийн ямар үндэслэлээр хэдэн хувь тооцож гаргаж байх талаар эрх зүйн орчин бүрдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, ажлаас халаад болдог биш гаргасан үр дүнгээр нь хариуцлага ярих тэр хариуцлага нь тодорхой мөнгөн дүнтэй холбоотой бол хуулийн хариуцлага хүлээлгэхээр хууль, шүүхийн байгууллагаар шийдүүлэхээр хүргүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, төслийн “орон нутгийн бонд, орон нутаг буюу аймаг, сум” гэсэн агуулгатай хэсгүүдийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10

Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Н.Наранбаатар: “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Энхболд, мөн газрын Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга Г.Нандинжаргал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Татварын ерөнхий газрын Татвар хураалт, удирдлага арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал, С.Төрмөнх байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны

Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Да.Цогтбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 51 минут үргэлжилж, 30 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 53,3 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Далайн Батбаяр, Жигжидийн Батжаргал, Хөххүүгийн Болормаа, Гомбын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Батжаргалын Заяабал, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Нанзадын Наранбаатар, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Ганзоригийн Тэмүүлэн, Банзрагчийн Түвшин, Даваагийн Цогтбаатар, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд ирсэн байна.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026 оны 06 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

2.Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлт

3.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026 оны 06 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг дэх асуудал.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий

газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Мэндсайхан танилцуулна.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр”-ийг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр соёрхон баталсан билээ.

Тус хэлэлцээр нь Монгол Улсын гадаад худалдааны урсгалыг нэмэгдүүлэх, экспортын боломжийг өргөжүүлэх ач холбогдолтой хэдий ч тарифын хөнгөлөлт эдлэх барааны жагсаалтад тамхи, тамхин бүтээгдэхүүн хамрагдсан нь төсөв, татвар болон нийтийн эрүүл мэндийн хувьд тодорхой эрсдэлийг бий болгож байна.

Тухайлбал, тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тариф 0 хувь болсноор импортын өртөг буурч, зах зээлийн үнэ хямдрах, улмаар хэрэглээ нэмэгдэх эрсдэлтэй. Энэ нь нийтийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс гадна гаалийн албан татварын орлого буурч, улсын төсвийн орлогын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл үүсэж болзошгүй юм.

Иймд Улсын Их Хурлаас хэлэлцээрийг соёрхон баталсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолыг баталж, тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэсэнтэй холбоотой төсөв, татвар, нийгэм, эдийн засаг болон нийтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тооцож, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн яамнаас Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн үндсэн зорилго нь тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тариф тэглэгдсэнээс үүдэн зах зээлийн үнэ буурах, нөлөөллийг сааруулах, тамхины хэрэглээг татварын бодлогоор зохистой түвшинд хязгаарлах, улсын төсвийн орлогын тогтвортой байдлыг хадгалахад оршино.

Өнөөгийн байдлаар тамхи, тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татварыг биет нэгжид суурилуулсан хэлбэрээр ноогдуулж байна. Харин хуулийн төсөлд одоо мөрдөгдөж буй зохицуулалтаас гадна импортын тамхи, тамхин бүтээгдэхүүнд гаалийн үнэд суурилсан хувь хэмжээний онцгой албан татвар ноогдуулах буюу биет нэгж болон үнийн дүнд суурилсан хосолсон татварын хэлбэрийг нэвтрүүлэхээр тусгалаа.

Ингэснээр импортын гаалийн татвар, гаалийн тариф тэглэгдсэнтэй холбоотой зах зээлийн үнэ огцом буурах, хэрэглээ нэмэгдэх эрсдэлийг бууруулах, мөн гаалийн албан татварын орлого буурснаас үүсэх төсвийн сөрөг нөлөөллийг нөхөх боломж бүрдэнэ.

Хуулийн төслийн хамт “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 117 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд боловсруулсан Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох Улсын Их Хурлын тогтоолын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг Байнгын хорооны эрхэм гишүүдээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайд баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Түвшин гишүүнээр тасаллаа. Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Ерөнхийдөө энэ Онцгой албан татварын хуулийг дэмжиж байгаа. Тэгээд биетээр болон үнэд суурилсан гэж байгаа. Тэгэхээр оруулж ирж байгаа гаалийн албан татвар бол үнэ дээр суурилж явж байсан байх. Тэгэхээр энэ биетээр болон үнэд суурилсан гэдгээ 1 дүгээрт жоохон тайлбарлаад өгөөч.

2 дугаарт яг одоо байгаа үнэтэй болон зах зээл дээр байгаа үнэтэй яг тэнцүүлж, яг одоо байгаа байдлаар нь тогтоосон уу, жоохон өсгөж байгаа юу.

3 дугаарт Тамхины тухай хууль хэлэлцэж байгаа үед магадгүй энэ вейп /vape/ болон янжуур тамхины татварыг нэмье гэж байгаа үед энд дахиад нэмэлт, өөрчлөлт орох боломжтой юу. Энэ 3 асуултад хариулаад өгөөч.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Гол асуудал нь юу л юм байгаа юм. Евроазийн 5 орноос гаалийн татваргүй тамхи импортоор орж ирэх гээд байгаа юм. Энэ 7 сарын 28-аас эхлээд хэрэгжинэ шүү дээ. Евроазийн хэлэлцээр. Тэгэхээр тэрний дараа хэлэлцээр маань хэрэгжээд эхлэнгүүт энэ 5 орноос гаалийн татваргүй орж ирэх юм байна. Тэгэхээр гаалийн татвараа бүгдэд нь тэгш тэглээд, онцгой дээр нь нэмээд өгчихье л гэсэн. Яг тэнцүү тэр хэмжээгээр. Тэгэхээр нөгөө өмнөх татварын юунд бол өөрчлөлт орохгүй. Авах татварын хэмжээнд.

Тэр хосолсон гэдэг нь юу вэ гэхээр энэ чинь бид нар онцгой албан татварыг өртгөөс нь авч байгаа шүү дээ. Тэгээд тэрнээс гадна ширхэг, одоо хайрцаг тамхин дээр 20 ширхэг гэх юм бол 1-ээс нь 850 төгрөг ч билүү ингээд аваад явж байгаа шүү дээ. Тэр нь ширхгээр гэж байгаа юм. Өртөг нь гэдэг нь гаальд мэдүүлж байгаа худалдан авсан үнийн өртгөөр гээд ингээд хосолсон татвартай явна л гэсэн санаа.

Адилхан ерөөсөө бид нар бол хөндөхгүй. Тэр гишүүдийн санаачилсан тамхины хууль бол тусдаа яваад л батлагдана. Тэглээ гээд энэ дээр ямар нэгэн өөрчлөлт орохгүй л гэсэн санаа. Болно болно. Тийм учраас нөгөө хосолсон гэж яриад байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Надад 1 асуулт байгаа тодруулаадхаарай. Тэр 1 бараан дээр давхар татвар ноогдуулж болох уу. 1 бараан дээр чинь үнийн дүнгээр нь тогтоочхож

байна. Дээр нь 30 хувь гээд хувилаад тогтоочхож байна. Ингээд 1 нэр төрлийн бараан дээр 2 татвар гэж л би ойлгоод байна шүү дээ. Энийг тайлбарлаадхаач. Индрийн микрофон.

Ч.Чимидсүрэн: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Сангийн яам Татварын бодлогын газар Чимидсүрэн. Тэгэхээр Онцгой албан татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт энэ дээр бол түрүүний сайдын хэлсэн дээр гаалийн татвараа тэглээд, одоо 30 хувь байгааг бүгдийг тэглээд, тэгээд онцгой албан татварынхаа хувь хэмжээг нь 30 хувь болгоод нэмж байгаа юм. Одоо практик дээр бол Онцгой албан татварыг зөвхөн биет хэмжээнд нь ноогдуулж байгаа. Тэгэхээр хосолмол буюу хайбрид хэлбэрээр гэсэн үг. Биет хэмжээ дээр нь бол онцгой албан татвараа ноогдуулаад, нэмэх нь 30 хувиар, үнийн дүнд нь 30 хувиар онцгой албан татварыг нэмэгдүүлнэ гэсэн үг. Тэгэхээр онцгой албан татвар маань биет хэмжээ болон үнийн дүнд суурилсан хэлбэрээр байна гэдэг нь энэ нэмэлт, өөрчлөлтөөр орж ирж байгаа юм.

Н.Наранбаатар: Татварынхаа хуульд чинь татварыг давхардуулж ноогдуулж болохгүй л гэж байх ёстой доо. Тэгэхээр давхардуулах биш хосолмол гэж ойлголт байгаа юм уу тээ. Уг нь аль нэгээр нь байх ёстой шүү дээ. Гэтэл энэ чинь хоёулаа болчихоод байгаа байхгүй юу. Үнийн дүнгээр 1 ноогдуулчхаж байгаа байхгүй юу. Тэдэн ширхэг нь тэд гээд, тэрнээсээ дахиад 30 хувиар дахиад ноогдуулна гээд, 1 тамхин дээр 2 онцгой татвар орж ирээд байгаа байхгүй юу.

Ч.Чимидсүрэн: Онцгой албан татвар гэдэг 1 л төрлийн татвар бий. Гэхдээ сууриа авахдаа тоо хэмжээнд болон үнийн дүнгээс суурилж байгаа хэлбэр нь бол ийм явж байгаа. Одоо бид нар практик дээр ч гэсэн автомашин дээр Онцгой албан татвараа ингэж тогтоож явж байгаа. Саяхан бид нар үндсэндээ эцсийн хэлэлцүүлгээр баталсан зүйл дээр цилиндрийн хэмжээнээс нь буюу тоо хэмжээнүүдээс нь нөлөөлж байгаа. Дээр нь 100 мянган доллараас дээш буюу өөрөөр хэлбэл 360 саяас дээшхэд нь 33 хувиар гээд бид нар бас тооцоод л явж байгаа.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж дууссан. Батжаргал гишүүн, Ганхуяг гишүүн нарыг асуултад нэмье. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амар амгаланг айлтгая. Биет хэмжээ, үнийн дүн 2-оос хамааралтай тогтоож болдог юм байжээ. Болно. Болгоё. Тэгвэл одоо мөрдөгдөж байгаа гаалийн татвар, онцгой албан татвар 2-ын чинь нийлбэр дүн хэд байгаа юм. Одоо та хэдийн оруулж ирчхээд байгаа гишүүдээс өргөн барьчихсан 1 бий, Засгийн газраас оруулаад ирчихсэн 1 бий. Энэ 2-ыг аваад үзэхээр зэрэг ямар хувьтай, ямар харьцаа өөрчлөлт байгаад байгаа юм. Энэ дээр тов тодорхой, тоо баримттай хариулт өгөөдхөөч гэдэг 1 ийм зүйл байна.

2 дахь зүйл. Эртээд бид хэд энд яриад, юунаасаа хамаарч татварууд нь өөр байх юм бэ гэдэг асуудал ярьсан юм. Мөн үү. Никотиноосоо хамааралтай байх уу, биет хэмжээнээсээ хамааралтай байх уу, дагалдах хэрэгслүүд дээрээ байх уу гээд ингээд олон ярьсан. Тэгээд шийдэл юмнууд ямархуу түвшинд ажлын хэсгээс гарч, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр ямар дүгнэлт гарсан бэ. Энэ өөрөө их сонирхолтой байгаа юм. Эндээс мэргэжлийн Байнгын хорооноос дүгнэлт очсон байх ёстой. Ийм ийм зүйлийг анхаараад, ингээд тогтоогоодхооч гэдэг ийм зүйл очсон. Дүгнэлт очсон. Тэрийг үндэслээд тэндээс ямар дамаа энэ дагасан

хууль дээр ямар шийдэл гарч, анхны хэлэлцүүлэг хийгдсэн бол. Энийг тодруулмаар байх юм.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг. Индрийн микрофон дээр хариулна.

Ч.Чимидсүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тамхины импорт болон татварын орлоготой статистик мэдээллийг эхлээд хэлье. 2025 оны гаалийн мэдээллээр тамхи, тамхин бүтээгдэхүүний нийт гаалийн үнийн дүн нь 322 тэрбум байсан байна. Мөн татварын дүн нь 305 тэрбум төгрөг байна. Үүнээс гаалийн татвар нь бол 84,3 тэрбум, НӨАТ нь 57,1 тэрбум, Онцгой албан татвар нь 164 тэрбум байгаа юм. Одоогийн байгаа зөвхөн биет хэмжээнд онцгой албан татварыг ноогдуулж байгаа тохиолдолд бол үнийн дүнгийн 34-40 хувийн үнийн дүнд татварын хувь хэмжээ эзэлж байгаа юм. Ингээд зүгээр энэ урьдчилсан байдлаар ажлын хэсэг дээр ярилцсан, гишүүдийн санаачил тоо хэмжээнд нь сууриалаад онцгой албан татварыг нэмсэн дүнгээр авах юм бол 57 хувь болно. Үнийн дүнд эзлэх татварын хувь хэмжээ нь 57 хувь болно гэсэн тооцоололтойгоор сүүлийн байдлаар ингээд хэлэлцэгдээд, ярилцаад, 57-60 хувь болж байгаа. Ийм тооцоолол нь хийгдээд явж байгаа юм байна.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Энэ чинь тамхитай холбоотой юм чинь асуухаар аль 1 талд нь хамаатуулчих гээд бас жоохон төвөгтэй юм байна лээ шүү дээ. Би энэ хамрын тамхийг асуух гэсэн юм. Энэ нэгжүүд нь ер нь яаж хоорондоо уялдаад байгааг ерөөсөө ойлгохгүй байна л даа. 20 хувь гээд үнийн дүнгээс нь л 20 хувь онцгой албан татвар ноогдуулах гээд байгаа юм шиг байна. Тэгэхдээ үнийн дүн юм уу, эсвэл грамм юм уу. Энэ никотин гээд уг нь тэр зуршил болгодог бодисыг нь агууламжаар нь, граммаар нь ингээд тооцоод явбал энэ хамрын тамхи ч байдаг юм уу, юу ч байдаг юм, тэр цахилгаан ч байдаг юм уу тооцоод явбал уг нь зөв юм шиг санагдаад байх юм. Тэгээд энэ хамрын тамхийг нь асуучихаар аль талд нь очиж наалдаж унах юм байгаа юм. Сүүлдээ энэ чинь тийм шинэ хамаатантай болсноо мэдсэн байна лээ шүү дээ би чинь. Тэгээд энэ хамрын тамхины талаар асуух гэсэн юм. Энэ никотинтой юм уу, зуршил бий болгодог юм уу гэдгийг 1 дүгээрт асуучихмаар байна. Энэ дээр нэг тодорхой хариу авчихмаар байна.

2 дугаарт, энэ татварын асуудлууд нь 2, 3 Байнгын хороон дээр тус тусдаа яваад байдаг. Тэгээд гишүүдийн асуудлынх ч тэнчээ нэг тусдаа яваад, Засгийн газрынх манай Байнгын хороогоор яваад, тэгээд энэ ингээд тус тусдаа яваад батлагдах юм уу, эсвэл нэгтгэдэг процесс явагдах юм уу, үгүй юу. Энэ чинь уг нь ингээд бүгдийг нь ингээд тавьж байгаад, хараад ингээ, тэгийг гээд яриад явах гэсэн энэ чинь ийм боломж ер нь гарах уу, гарахгүй юу. Энийг Байнгын хорооны дарга хариу өгмөөр байх юм.

Тэгээд энэ татварын бодлого бол Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудал. Тэгээд тамхи болохоороо эсвэл хамааралгүй өөр Байнгын хорооных болчихдог юм уу. Тэгээд бид нар энэ чинь ингээд тусад нь явчихдаг, нөгөө талд нь шал өөр юмнууд яригдаад яваад байдаг. Тэгээд яг эцсийн дүндээ яг ямар татвартай болох гэж байгааг нь хэн ч ер нь ойлгохоо больчихлоо л доо. Тэгээд энэ дээр хариу авчихмаар байна.

Н.Наранбаатар: Юуны татварын хувьд тусдаа явна гээд түрүүн Сангийн сайд хариулчихсан. Тусдаа явна. Засгийн газрынх бол энэ явдгаараа явна гэсэн. Нөгөө

Номинчимэг гишүүнийх тусдаа. Одоогоор тэгвэл хууль санаачлагчаас ямар нэгэн санал ирээгүй тусдаа явж байна. Хэрвээ санал ирвэл тэгээд л нэгтгэх эсэхийг шийдээд л явах байх. Бусад хариулт дээр индрийн микрофон дээр хариулъя.

Ч.Чимидсүрэн: Хамрын тамхин дээр бол гаалийн татвар үнийн дүнгээс нь 20 хувиар тооцож гаалийн татвар авч байгаа. Энийг гаалийн татварыг нь тэглээд хамрын тамхийг тэглээд, онцгой албан татвар дээр 20 хувь гэдэг энэ хувь хэмжээгээрээ л оруулж ирж байгаа. Эрүүл мэндийн яамныхан дүгнэлт гаргаад явж байгаа. Бид нар тэр тал дээр нь бол ороогүй. Эрүүл мэндийн яамныхан тусдаа ажлын хэсэг, бүр дэд ажлын хэсэг гараад ажиллаад явж байгаа.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн яг тэр хамрын тамхинд ер нь яг ямар, ямар бодис байдаг юм. Тэгээд энэ дээр цөмөөрөө бодлого гаргаж явахгүй бол үнэхээрийн хамрын тамхинаас болоод зуршил болоод хүүхдүүд энийг татаад байдаг юм уу. Тэгээд энэ дотор никотины агууламж байхгүй бол энэ чинь ингээд бусад тамхитайгаа хамт ингээд хэлэлцэгдээд явах нь зөв үү, үгүй юу. Энэ дээр санал, дүгнэлт эд нар гаргуулбал яасан юм бол дарга аа. Яагаад энийг онцгой тогтвортой болгох гээд байгааг би өөрөө гайхаад байна л даа. Тэгээд манай татварын алба бол энийг чинь мэдэхгүй юм байна шүү дээ.

Н.Наранбаатар: Гаалиас хариулъя. Индрийн микрофон.

Ч.Чимгэрэл: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Гаалийн ерөнхий газар Чимгэрэл байна. Хамрын тамхины хувьд бол нөгөө олон улсын ангиллаараа тамхин бүтээгдэхүүнд орж явдаг. Тамхин бүтээгдэхүүний хувьд навчны ургамлаас гаргаж авсан, үүрүүлсэн, хаягдлаас нь гаргаж авсан, үнэр оруулсан ийм хэсэг нь бол хамрын тамхи нэлээн сайн нягтруулж боловсруулсан ийм тамхи ордог юм байна лээ. Татварын хувьд бол гаалийн тарифын хувь, хэмжээ 20 хувь, нөгөө Евроазитайгаа холбогдоод, Евроазийн хэлэлцээрийн хүрээнд орж байгаа тамхин бүтээгдэхүүний гаалийн татварыг нь тэр чигт нь тэглээд, түүнийгээ онцгой албан татвар гэдэг нэрээр оруулж ирж байгаа гэсэн үг.

Тийм учраас гаалийн албан татвар нь 0 хувь хэмжээтэй, Онцгой албан татвар нь үнийн дүнгээс 20 хувь, биет нэгжид ноогдох хэмжээ бол онцгой албан татвар дээр байхгүй, чөлөөлөгдсөн байдаг.

Н.Наранбаатар: Нэмж хариулъя гэж байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Мөнхбаясгалан гишүүнээр, Сайнзориг гишүүнээр тасаллаа. Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Ер нь тамхины татвар дээр никотины хэмжээ болон нэг саванд байх савлагаа нь хэмжээнээс хамаарахаас гадна утаа ялгаруулж байгаа гэдэг нь их том үзүүлэлт шүү дээ. Яагаад гэвэл утаа ялгаруулна гэдэг нь орчныхоо бусад хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөл үзүүлж байгаа юм. Хүн өөрөө хувь хүн хэрэглэж байгаа хүн тэр хорт бодис хэрэглэж эрүүл мэндэд нь нөлөө үзүүлэхээс гадна, утааны хэмжээ гэдэг бол өөрөө их том. Шатахуун дээр харьцуулж хэлэх юм бол илүү хүхэр агуулсан бүтээгдэхүүнд нь илүү татвар ногдуулах зарчим руу ер нь цаашдаа явах ёстой. Тийм ч учраас энэ евро гэдэг энэ стандарт руу бол шатахууны хувьд бол шилжиж байгаа. Аль болох хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хор багатай. Түүнтэй адилхан энэ утаа ялгаруулдаг тамхи болон утаа ялгаруулдаггүй тамхины хооронд энэ ногдуулж байгаа татварын хэмжээ нь 1 дүгээрт утааны хэмжээ, 2 дугаарт агуулагдаж байгаа никотины хэмжээ, 3 дугаарт нь савласан тоо

хэмжээнээсээ хамаараад тарифын хувьд ийм үе шаттай ийм л ... би цаг дээрээ юмаа ярьчих уу. Больё больё. Би дараа нь дахин ярья дахиад цагаа авъя.

Н.Наранбаатар: Бадамсүрэн гишүүн яах юм. Дахиад эхнээс нь цаг авах уу. Эхнээсээ өгчих.

М.Бадамсүрэн: Тэгэхээр гол нь татвар тогтоохдоо дараа нь гарах үр дагаврыг маш сайн тооцох хэрэгтэй. Энэ дээр хэрвээ хэлэлцэх эсэх дэмжигдвэл ажлын хэсэг, Байнгын хороо энэ дээр онцгой анхаарах ёстой байх гэж бодож байна. Тэгэхгүй бол дараа нь бүх юм болсны дараа юм яриад байх бол аягүй зохисгүй шүү дээ.

Тийм учраас 1 дүгээрт никотины хэмжээ тамхины тухайд, 2 дугаарт нь тэр нэг хайрцагт савласан хэмжээнээс нь ногдуулж аль болох бага хэрэглэх, аль болох бага хорт бодистойг үнэхээр хэрэглээнд байгаа бол энэ дээр татвар нь уян хатан байх зохицуулалт байх ёстой. Тэрнээс гадна түрүүн би Байнгын хорооны хурал дээр Эрүүл мэндийн сайдаас тодорхой мэдээлэл авъя гэсэн. Тэрний дагуу мэдээлэл ирсэн байна. Энэ дээр гол агуулга нь бол ийм байна шүү дээ. Ерөөсөө ялгаруулж байгаа утаа гэдэг бол энэ тамхи, тамхины эсрэг олон улсын конвенцод зааснаар хамгийн хортой үзүүлэлт гэж заасан байгаа юм. Энэ нь бол утаа ялгаруулж байгаа нь өөрөө хамгийн их орчноо буюу тэр ойр хавьдаа байгаа хүмүүсээ хордуулж байгаа юм. Хувь хүн өөрөө хортой бодис хэрэглэж эрүүл мэндээ муутгахаас гадна. Тийм учраас энэ утаа их ялгаруулж байгаа хэмжээг нь бас татвар ногдуулахдаа харгалзаж үзэх хэрэгтэй. Тэгээд энэ чинь ийм нөгөө ялгаатай байдлыг олон улсын конвенц болон энэ судалгаа, дүгнэлтүүд, эрүүл мэндийн байгууллага, лабораторийн шинжилгээ, дүгнэлт энэ зүйл дээр нь үндэслэж маш сайн тогтоохыг хэлэлцүүлгийн явцад илүү сайжруулах хэрэгтэй байх гэдэг ийм саналыг л гол нь хэлэх гээд байгаа юм.

Архи дээр ч гэсэн адилхан шүү дээ. Тэгээд шимийн архи болон шар айргийн татвар хэд дахин бага байдаг юм байна лээ шүү дээ. Цагаан архи болон вискинээс. Тэгэхээр тамхин дээр ч гэсэн яг энэ бодлогоо барьж, хамгийн хортой бодис багатайд нь болон хамгийн их хортой бодис ялгаруулж байгаа 2-т нь татварын хувьд бол ийм уян хатан, тэгээд тарифын хувьд ялгаатай байж бодох хэрэгтэй. Тэгэхгүй 100 хувь хориглохгүй гэж байгаа бол захиргааны арга хэрэглэхгүй гэж байгаа бол татварын аргаар л зохицуулдаг шүү дээ. Аливаа ийм онцгой татвартай бүтээгдэхүүнийг. Тэгээд энэ чиглэл рүүгээ илүү уян хатан цаашид тогтоох талаар Байнгын хороо, ажлын хэсэг дээр анхаарч өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Н.Наранбаатар: Түвшин гишүүн үг хэлнэ.

Б.Түвшин: Тамхины татварын асуудал чинь үндсэндээ 3 хуулийн асуудал явагдаад байна шүү дээ. Одоо энэ гаалийн татварыг Евроазийн хэлэлцээртэй холбогдуулан тэглээд, оронд нь онцгой албан татварыг яг тэрэнтэй тэнцүү хэмжээгээр оруулж ирье гэж байгаа бол зарчмын хувьд зөв. Энэ чинь одоо байгаа зах зээлийг хөдөлгөөнд оруулахгүй гэсэн үг шүү дээ. 1 талаасаа.

Тэгвэл энэ хуулийн хэрэгжилт хэзээнээс эхлэх вэ гэхээр Евроазийн хэлэлцээр эхэлж байгаа үетэй зэрэгцээд эхлэх нь байна. Тэр үед чинь Засгийн газрын өргөн барьсан болон Номинчимэг тэргүүтэй гишүүдийн өргөн барьсан Тамхины хууль батлагдсан байх уу, батлагдаагүй байх уу гэдэг дээр бас тооцоолол хийх хэрэгтэй байгаад байгаа. Ер нь тамхинд тавигдах суурь хортой бодис буюу бид нарын хэлдгээр тэр никотин гээд байгаа зүйлд л хувь тэнцүүлэн ноогдуулах асуудал

байгаа шүү дээ. Никотиныг нь бууруулах замаар тамхины хэрэглээ хороос нь ангижруулах гэдэг ийм дадал үйл ажиллагаа л болж байгаа болохоос тэр вейп гэдэг нь тамхинаас гаргах арга хэрэгсэл гэж үзэгдэж байсан. Өнөөдөр нөгөө талаасаа бас хэтэрхий залуу үеийг уруу татаж байгаа гэдгээрээ бас магадгүй тийм буруу дадал руу оруулж байгаа гэдэг асуудал ч 2 талаасаа хөндөгдөж байгаа. Тэгэхээр өнөөдөр яг энэ татвар тогтоох суурь асуудал бол өнөөдрийн энэ онцгой албан татварыг аваачаад яг гаалийн албан татвартай тэнцүүлээд тавьж байгаа нь яг эдийн засгийнхаа хувьд тогтвортой байдлыг хангаж байгаа боловч яг тэр 2 тамхины хуулийг хэлэлцэж байгаа үед нэгжид ногдох никотинтой яаж уях вэ гэдэг асуудлыг давхар ярихгүй бол өнөөдөр бид нар 7 сарын байдлаараа энийгээ хэлэлцье гээд баталдаг. Яг маргааш нь дахиад нэгжид ноогдох никотинд нь ноогдуулах асуудал хөндөгдөөд гараад ирж магадгүй байгааг ер нь анхаарах хэрэгтэй байгаад байгаа юм.

Ер нь энэ 2 тамхины хэрэглээний асуудал дээр олон улсын судалгаа энэ тэр гээд л ингээд л яриад байгаа. Гэхдээ нэг зүйлийг бас анхааруулъя гэж бодоод байгаа юм. Төгрөгийн үнэ ханшаас гадна бараа хоорондын жишиг ханш гэж ерөөсөө байгаад байгаа. Аль ч эдийн засагт энийг ил тод ярихгүй ч гэсэн ер нь ярьдаг.

Тухайлбал, сая Монголын зах зээл дээр махны үнэ өсөхөд дагаад бусад бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөж байгаа. Тийм учраас ерөөсөө энэ тамхийг тодорхой үе шаттайгаар бага хэмжээгээр үнэ нэмэгдүүлэх тэр татвар өсгөөд явна уу гэхээс огцом нэмэгдүүлэх нь зах зээл дээрх бусад үнийн харилцаануудыг өөрчилж, эдийн засгийг өөр хөдөлгөөнд оруулж магадгүй байгаа шүү гэдгийг бас анхааруулж хэлье. Тэгээд тамхин дээр одоогийнхоосоо эхлээд энэ 3 хууль гурвуулаа цаашаа явахад никотин дээр суурилсан байх нь зүйтэй шүү гэдэг саналыг бас хэлье.

Н.Наранбаатар: 1 зүйлийг тодруулж хэлэхэд энэ 2 хуулийн зорилго нь өөр. Энэ Онцгой албан татварын Засгаас өргөн барьсан нь бол Евроазийн хэлэлцээртэй холбоотой тэглэсэн гаалийн татварыг онцгойгоор нөхөх зорилготой. Номинчимэг гишүүний өргөн барьсан нь тамхины хэрэглээг хязгаарлах, хүүхдүүдийг тамхинаас хамгаалах ерөнхий ийм хууль байгаа учраас тусдаа ингээд яваад байгаа юм.

Цаг хугацааны хувьд энэ чинь нөгөө хэлэлцээр батлагдахаас өмнө хэрэгжчихсэн байх ёстой шүү дээ засгийнх чинь. Номинчимэг гишүүнийх хэзээ батлагдах нь бол бас тодорхой биш байгаа шүү дээ. Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Би энэ тамхин дээр тавьж байгаа онцгой албан татварын асуудал, үүнтэй боловсруулсан хуулийн өөрчлөлтийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Нэлээн эртхэн шийдчих байсан юм. Энэ тамхины хуулиас ч өмнө шийдчих байсан юм. Одоо ингээд зэрэгцүүлээд явахаар тэнд байгаа асуудлыг л ярих гээд байгаа юм шиг. Энэ бол нөгөө Евроазийн хэлэлцээртэй холбоотойгоор гаалийн албан татвар тэглэгдсэнтэй холбоотой бодлогын асуудал байхгүй юу. Жоохон цаг хугацаа алдаж орж ирээд байгаа ийм зүйл байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдийг бол ялгаж салгаж, энийгээ бас яаралтай горимоор шийдээд явчих нь зүйтэй гэж би хүсэж байгаа юм. Тусдаа учраас уг асуудлыг Байнгын хороон дээр бас бариад ч юм уу, янз бүрийн байдлаар гэхгүйгээр аль болохоор шуурхай анхны хэлэлцүүлгээр нь батлаад явчихъя. 30 хувь бол тодорхой түвшинд тавигддаг л хувь хэмжээ.

1 зүйл байгаа. Мэдээж бид хэд тодорхой түвшинд тамхидалтыг бууруулах үүднээс хүртээмж болон эсвэл тодорхой үнийн зохицуулалтаар л бууруулах гэж

оролддог дэлхий нийтийн зарчим байгаа. 1зүйл энэ дээр нөгөө хар зах зээл үүснэ. Энэ хар зах зээлээс л урьдчилан сэргийлэх асуудлыг манай Сангийн яам, гааль татварын газрынхан, хууль сахиулах байгууллагатай хамтарч явах ёстой. Угаасаа ямар ч зүйлүүд дээр энэ албан ёсны зах зээлтэй зэрэгцээд иймэрхүү зүйлүүдтэй зэрэгцээд бас хар зах зээл бол үүсдэг. Тэгэхээр энийг л бид цаашдаа гаргуулахгүй байх үүднээс ер нь тамхи, тамхин бүтээгдэхүүнүүд аль аль боомтоор ер нь түлхүү орж ирдэг юм. Тэндэх хяналт шалгалт, хүний нөөц, эргээд тэр нөгөө тамхины асуудал дээрх илрүүлдэг асуудлууд чинь нохой байдаг юм уу, яг зориулалтын бэлтгэгдсэн албаны нохойнууд байгаа гэх зэрэг ийм зүйлүүдийн төсөв хөрөнгүүдийг битгий нэг татчихаасай гэж бодоод байгаа юм. Тэгээд зарим зүйлүүд дээрээ нөгөө нийтээрээ төрийн албыг цомхотгох ёстой гэнгүүт нь ингээд бужигнаж дагаад байх ёстой албан тушаалтнууд нь ингээд явчихдаг ийм зүйл байх юм. Тийм учраас энэ онцгой албан татвар тавьж байгаагийн хэрээр нөгөө талдаа хар зах зээл үүснэ. Хар зах зээл дээр бас Засгийн газар жоохон төлөвлөгөөтэй, тактиктэй, энэ орж ирж байгаа боомтуудыг дагасан хүний нөөц болон энэ хар зах зээл дээр орж ирэх бүтээгдэхүүнээс урьдчилан сэргийлэх гэдэг юм уу, зах зээлд тарахгүй байх энэ бодлогоо бас яг энэ хуулиар бол биш. Энэ зохион байгуулалтын ажил бас анхаараарай л гэж хэлэх байна.

Тэгэхээр би Мэндээ сайдад эцэст нь юу хэлэх гэж байна гэхээр энэ хууль батлагдсан тохиолдолд Засгийн газар дээр энэ хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор хууль сахиулах байгууллага болон гаалийнхандаа бас зохион байгуулалт, бүтцийн чиглэлүүдээ сайн өгөөрэй. Хүссэн, хүсээгүй энэ чинь бас тийм юм руу орж байгаа шүү. Тэгээд нөгөө дамын наймаа гэдэг шиг л энэ чинь шал өөр түвшинд түгээлтүүд яваад эхэлнэ гэсэн үг. Энийгээ анхаарна биз дээ.

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ.

Л.Мөнхбаясгалан: Энэ хамрын тамхинд онцгой албан татвар тавина гэдгийг чинь ерөөсөө ойлгохгүй байна. Хамрын тамхи никотинтой, донтуулдаг тамхин бүтээгдэхүүн юм бол одоо монгол хүмүүс чинь уулзахаараа хөөргөлдөг дөө. Та сайхан хаваржиж байна уу. Та сайхан зусаж байна уу. Энийг хориглох юм уу. Энэ бусдад буруу үлгэр дуурайлал, хүүхдэд хөөргөөрөө тамхилдаг шүү дээ. Энийг хориглох хууль араас нь гарах уу. Тэгэхээр энэ бол арай л дэндүү туйлшрал мэт санагдаж байна. Тэгээд нөгөө вейп, янжуур тамхи гэж хоорондоо муудалцаж байгаад, зүв зүгээр тэнд байсан хамрын тамхийг буцаагаад татаад оруулж ирээд, одоо нэг мөсөн бүр хөөргөлөх өв соёлыг нь хүртэл хориод. Энэ чинь тамхи юм бол зөвшөөрөгдсөн газар татах тийм үү, зөвшөөрөгдөөгүй газар олон нийтийн газар хориглох. Одоо энэ Байнгын хороо дээр тэнд хөөргөлж байна шүү дээ. Энийг хорих уу. Хүүхдүүд нөгөө цагаан сараар ингээд миний хүү нааш ир гээд хөөргөлдөг. Энийг хорих юм уу. Энэ үнэхээр туйлшрал шүү нөхөд өө. Болохгүй шүү дээ. Санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Энэ дэгээрээ ийм юм байна. Энэ өнөө яаралтай горимоор явж байгаа учраас нөгөө 2 хоногийн өмнө энэ тэр гэхгүй, анхны хэлэлцүүлэг энэ чинь бол хэлэлцэх эсэх. Дараа нь анхны хэлэлцүүлэг маргааш ч юм уу, нөгөөдөр ингээд явчихна. Тэгэхээр та шууд хэзээ ч саналаа гаргаад, санал хураалгаж болно. Энэ чинь хэлэлцэх эсэх юм чинь. Булгантуяа гишүүн үг хэлнэ.

Х.Булгантуяа: Саяын уг нь Мөнхбаясгалан гишүүнийх дээр тайлбар өгүүлчихсэн байсан бол Сангийн яамнаас зүгээр байсан юм болов уу. Тэгье тэгэх үү. Мэндсайхан сайд өгчхөөч. Тэгэхгүй бол олон нийт сонсож байгаа.

Н.Наранбаатар: Мэндсайхан гишүүн үг хэлнэ.

3.Мэндсайхан: Гишүүдэд бас би үг хэлэх гэсэн юм. Энэ оруулж ирж байгаа Засгийн газрын ... Лодойсамбуу гишүүнээ, та бас сонсоод авчих. Ойлголтын зөрүүтэй байх шиг байна. Энэ онцгой татвар ямар учиртай вэ гэхээр Евроазийн хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газар 2 жилийн хугацаатай түр хугацаагаар орчхож байгаа. Тийм ээ. 7 сарын 28-аас хэрэгжээд эхлэхээр өмнө гаалийн татвартай явж байсан бараанууд гаалийн татваргүй болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 5 орноос гаалийн татваргүй орж ирээд, бусад орноос гаалийн татвартай ороод ирэхээр бид нар шууд татварын бодлогоороо өрсөлдөөнийг дэмжээд эхэлж байгаа байхгүй юу. Зөрүүтэй өрсөлдөөн. Тэгэхээр зэрэг гаалийн татварыг нь бүгдийг нь тэглээд, онцгой дээр нь шингээж өгөөд, нэг ёсондоо хамрын тамхи дээр жишээлбэл гаалийн татвар байсан. Тэгэхээр нь тэрийг нь онцгой болгоод өгчихөөр энэ бусад улсуудтай адилхан татвараа төлөөд явна л гэсэн санаа байхгүй юу. Түүнээс биш ямар нэгэн давуу тал олох биш, харин давуу тал олгохоос нь сэргийлж байгаа асуудал. Өөр татварыг нь би ойлгож байна. Тэгэхдээ бид нарын зохицуулах хоёрхон л татварын хэлбэр байгаа шүү дээ. Тэр нь нөгөө хамрын тамхи, энэ нь нөгөөхийг чинь юу гэдэг билээ. Утаатай тамхийг онцгой татвар дээр нь шингээж өгөхгүй бол гаалийн татвараа аваад, тэр 5 улсаас бас гаалийн татваргүй тамхинууд ороод ирнэ. Истаны орнуудаас. Ингээд бид нар тамхийг хямд тамхиар зах зээлийг дэмжиж байгаа татварын бодлого болчих гээд байгаа байхгүй юу. Тэрийг л арилгах гээд байгаа юм. Түүнээс биш тэр гишүүдийн өргөн барьсан хуультай бол энэ ямар ч хамаагүй.

Н.Наранбаатар: Золжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Золжаргал: Насаараа тамхи татаж байгаад хаячихсан хүний хувьд 2 юм хэлье. Тамхийг байна шүү дээ ингээд татахаар нөгөө тамхины навч чинь шатаад, тэндээс дутуу шатсан ийм утаа гардаг шүү дээ. Тэр нь ингээд очоод юман дээр суугаад, нялцгай шингэн болохоороо таар буюу нөгөө давирхай гэдэг. Тэгээд ингэж уушгин дээр суувал муу. Гэхдээ тэр хамгийн гол нөгөө тархинд үйлчилдэг бодис нь тэр биш байхгүй юу. Тархинд үйлчилдэг бодис нь болохоор никотин. Тэгээд нөгөө никотиныг нь шатдаггүй, бага давирхайтай, тэгэхдээ ялгаагүй никотины үйлчилгээг нөгөө вейп энэ тэрээр авч байна шүү дээ. Тэгэхээр агуулга нь тамхины үндсэн тархинд үйлчилж байгаа.

Миний хэлэх гээд байгаа зүйл юу вэ гэхээр ийм гаа, чихэр байна. Кило, зин, пабло энэ тэр гээд янз янзын нэртэй. Энэ чихэр, энэ гаа бол никотины баяжмал. Тэгээд ингээд тайлбар дээрээ та тамхи татаж өмхий үнэр гаргахгүйгээр никотиныхоо хэрэгцээг хангаад ингээд гоё болчихно гээд биччихсэн. Энийг яах вэ, хэрэглэхэд 16грамм хүч энэ тэр гээд никотины уут гэж нэрлэдэг. Энийг насанд хүрсэн хүмүүс хэрэглэж болно л доо. Тэрүүгээр ингээд тархиа өдөөгөөд сайхан амраад явдаг хүмүүсийнх нь өөрсдийнх нь асуудал биз. Хүүхэд бол болохгүй. Үгүй ээ, энийг чинь харин хүүхдүүд аймар их хэрэглэж байна. Ерөөсөө сургуулиуд битүү хэрэглэж байна. Тийм учраас би энийг цохон тэмдэглээд байгаа байхгүй юу. Ийм юмыг тэр тамхиных нь ангилалд нь оруулах, тэгээд энэ Евроазийн холбооны нөгөө татварын хөнгөлөлттэй юмнууд дээр чинь онцгойгоор орж ирэхгүй бол тамхи чинь байна шүү дээ татдагаас гадна шингэн савтай, чихэр хэлбэртэй, никотин хангаж ингээд өөр хэлбэрээр орж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр татварын бодлого дээр тэр никотинтой нь холбож тавих хэрэгтэй байна. Тэгээд энэ бол чихэр биш. Энэ хүүхдүүдийн хэрэглээд байгааг таслан зогсоох хэрэгтэй. Тэрнээсээ хамаараад дараа дараагийн гүн хамааруулдаг бодис руу орох ийм эрсдэлтэй нөхцөл байдал

маш өргөн хүрээгээр тархчихсан байна. Тэр мэдээллүүдийг хүмүүс ирүүлээд байгаа учраас би бүр зориуд нэр устаа нь гаргаж тавьж байгаа юм. Эцэг эхчүүд бас анхаарах хэрэгтэй.

Н.Наранбаатар: Булгантуяа гишүүн үг хэлнэ. Нэрийг оруулаарай.

Х.Булгантуяа: Би зүгээр ингэж бодоод байгаа юм. Яах вэ, одоо гаалийнхыг нь болиулчихсан учраас онцгой дээр тавиад ямар ч байсан адилхан орлогоо авах ёстой гэсэн өнцгөөс яриад байх шиг байна. Уг нь бол онцгой албан татварын чинь зорилго нь хүний эрүүл мэндэд, дээр нь байгаль орчинд хор хөнөөлтэй, үүнийг бас зохицуулах үүднээс дэлхийн улс орнууд бас онцгой албан татвар тавьдаг. Тийм ч учраас манай Онцгой албан татварын тухай хууль дээр бүх төрлийн согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, авто бензин, дизелийн түлш, суудлын автомашин, газрын тос, тэгээд чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус гэж байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө онцгой албан татварынхаа үзэл санаатай 1 дүгээрт нэгэнт тэндээсээ чадахаа байчихсан юм чинь онцгой дээр тавиад татвараа авъя гэдэг чинь 1 дүгээрт жоохон зөрчих юм биш үү.

2 дугаарт би тэгэхдээ энэ хуулийг бол дэмжиж байгаа юм. Ерөнхийд нь бол дэмжиж байгаа. Сайнзориг гишүүн нарын хэлж байгаа одоо ингээд татвар нэмэгдчихээр хууль бус наймаа цэцэглэх юм биш үү гэдэгтэй би санал бол нийлэхгүй байна. Валютын сангийн хөтөлбөрийн хувьд бид нар тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлсэн. Тэгэхэд бас яг ингэж хэлж байсан. Янз янзын маш их лобби, дарамт орж ирэх гэж үзэж байсан. Тэгээд тэр үед Сангийн сайд бол үгүй ээ, тийм юм байхгүй. Мэдээж хувь хүний хэрэглээ магадгүй арай өндөр байх юм бол тэгж оруулж ирэх гэж үзэж магадгүй. Гэхдээ том үйлдвэрлэгч та нар борлуулагч нар та бүхэн хүмүүсийн машинд пачка пачкаар нь ачаад, хил давуулаад Монголд оруулж ирж зарах гэж оролдоно гээд үз дээ. Энэ бол угаасаа 1 дүгээрт боломжгүй.

Тэгэхээр энэ эрүүл мэндэд хор хөнөөлтэй хэрэглээг бууруулахад дэлхий даяараа 2, 3 аргыг хэрэглэдэг.

1 дүгээрт ерөөсөө үнэ бол өндөр байх ёстой.

2 дугаарт хэрэглэхдээ тэр авдаг нөгөө гоё кайфтай чанарыг нь бууруулах ёстой гэнэ. Тэгэхээр жишээлбэл манай Эрдэнэчимэг гишүүн нарын баталсан тамхины хуулийн үр нөлөөгөөр нийтийн газар тамхилахад их хэцүү болсон нь тамхины хэрэглээг бууруулахад нөлөөлнө.

3 дахь нь мэдээж зар сурталчилгаа, дээрээс нь нэмээд бага наснаас үүнд дасан зохицохыг бас бууруулах ёстой. Тэгэхээр энэ юу нэмэгдсэнээр нэг их онцгой албан татвар ч байдаг юм уу тамхин дээр нэмснээр би бол хууль бусаар хилээр оруулж ирээд л ингээд байх тэр нь бол гайгүй байх. Нэг үеэ бодвол манай гаалийн цахимжилт энэ тэр сайжирсан учраас энэ дээрээ бол харьцангуй гайгүй байх гэж бодож байна.

Харин түрүүний Мөнхбаясгалан гишүүний хэлж байгаа санал дээр бол анхаарч үзэх нь зүйтэй гэж бодож байна.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Тэгээд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явуулна. Бадамсүрэн гишүүн санал хураалтад бэлдээрэй.

Хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ. 50 хувьтай.

Цогтбаатар гишүүн горимын санал гаргая.

Да.Цогтбаатар: Бүлгийн гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Сая санал хураалтад төхөөрөмждөө амжиж санал өгч чадсангүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт хийж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 55,6 хувиар горимын санал дэмжигдлээ.

Одоо үндсэн санал хураалт. Санал хураалт. 55,6 хувиар дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55.6 хувиар дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Булгантуяа гишүүн танилцуулна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

15.39 цаг.

2 дахь асуудал.

Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Үндэсний аудитын газраас Хосжаргал Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын менежер, С.Бат-Эрдэнэ Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын ахлах аудитор, С.Оюун-Эрдэнэ Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын Өгөгдлийн шинжилгээний ахлах аудитор, Мөнхбаатар Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч, Туяа архитектор, Данаасүрэн Удирдлагын академийн Эдийн засаг, санхүүгийн тэнхимийн эрхлэгч,

Энхчимэг Монголын хуульчдын холбооны хуульч, Мөнхбат Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн мэргэжилтэн, Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын Дэд бүтцийн хэлтсийн дарга, Энхбаяр судлаач.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Золжаргал нарын 25 гишүүнээс 2026 оны 05 сарын 01-ний өдөр нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн талаар ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлсний дагуу сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Дээрх сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Золжаргал танилцуулна.

Ж.Золжаргал: Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайлангийн санал, дүгнэлт.

Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар иргэн мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан.

Нийслэлийн төсвийн зарлагад хяналт тавих талаар олон иргэдээс тухайлбал нийтийн өргөдлийн D-petition-ээр дамжиж хүсэлтүүд ирж байсан. Энэхүү нөхцөл байдалтай холбогдуулаад ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад хандаж гаргасан. Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулахыг дэмжиж, Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Батбаяр, Батболд, Баярмаа, Бейсен, Бямбасүрэн, Галбадрах, Ганбаатар, Заяабал, Лодойсамбуу, Лүндэг, Мөнхбат, Мөнхбаясгалан, Мөнхсайхан, Мөнхсоёл, Мөнхтулга, Наранбаяр, Пунсалмаа, Соронзонболд, Тэмүүжин, Хэрлэн, Цогтбаатар, Энхтүвшин, Эрдэнэболд, Золжаргал нарын 25 гишүүн гарын үсэг зурсан болно.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийн тухай” 02 дугаар тогтоолоор нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал сэдвээр ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Золжаргалыг томилсон.

Мөн Төсвийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 19-ний 03 дугаар тогтоолоор уг сонсголын бэлтгэл хангах ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Алтаншагай, Батболд, Баярмаа, Бум-Очир, Заяабал, Золжаргал, Лодойсамбуу, Сайнзориг, Хэрлэн, Цогтбаатар нарын 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшинийг томилсон болно.

Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд холбогдох төрийн байгууллагуудаас баримт бичиг гаргуулан авч, нотолгоонд суурилсан дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн 10

шинжээчийг Төсвийн байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 4, 6-ны 06 дугаар тогтоолоор томилон ажиллуулсан.

Ерөнхий хяналтын сонсголын үеэр 2 өдрийн турш нийтдээ 182 оролцогч сонсголд биечлэн оролцож, санал, тайлбар, мэдээлэл өгсөн. Хуульд заасны дагуу олон нийтэд нээлттэй мэдээлэх үүднээс Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизээр шууд дамжуулсан. Хэл, яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор дохионы хэлмэрчтэйгээр дамжуулсан. Мөн хэвлэл мэдээллийн 13 сайт, 8 телевиз шууд дамжуулсан байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу санал хэлэхээр хүсэлт гарган бүртгүүлсэн, цахим хуудсаар саналаа ирүүлсэн 3 иргэн, заалнаас 26 нийт, 29 иргэн санал, тайлбар, үг хэлсэн.

Сонсголд нийслэлийн төсвийн бие даасан байдал, бонд гаргалт, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй, Төсвийн тухай хуулийн 57.2, 57.3 дугаар зохицуулалтуудын хийдлийг арилгах шаардлагатай 7 зам, тээврийн төслүүд нь 26 их наяд хөрөнгө оруулалттай, ДНБ-ий 32 хувьтай дүйхүйц хэмжээний мөнгөн дүнтэй. Хоорондоо нэгдсэн төлөвлөлт, тооцоо байхгүй. Өвлийн матрицын хуучирсан 2027, 2017 оны судалгаагаар тооцсон. VRT хамгийн боломжтой 2 дугаар тойрог зам, Туулын хурдны зам хамгийн асуудалтай. Төсөв, мега төслийн мэдээллийг бодитоор ил тод болгох, нийслэлийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өсөлтийг хязгаарлах, төрийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, иргэдийг ажил, орлоготой болгох замаар түгжрэлийг шийдэх, нийслэлийн өмнөх удирдлагаас хариуцлага нэхэх, Сэлбэ дэд төвийн ажлыг гадаадын 2 компанид өгөхөөр байсныг тэмцэж, Монгол аж ахуйн нэгжүүд оролцуулсан. Монгол барилгачид чадварлаг тул төр итгэх ёстой.

Туйлын хурдны замын төслийн хэрэгжилттэй холбоотойгоор иргэдийн оролцоо, мэдээллийн хүртээмж, байгаль орчны үнэлгээний баримт бичиг төслийн хэрэгжилтийн хууль, эрх зүйн үндэслэлтэй холбоотой асуудлаар байр сууриа илэрхийлсэн.

2-т нь Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн дагуу дэгээр Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай, Баатархүү, Батболд, Баярмаа, Батнайрамдал, Булгантуяа, Ганзориг, Жаргалан, Лодойсамбуу, Мөнхсоёл, Наранбаяр, Сайнзориг, Үүрийнтуяа, Цогтбаатар, Энхтүвшин нар асуулт асууж, санал хэлсэн. Батболд гишүүн буцаж орж ирэх байх. Гишүүд хяналтгүй мега төслийн хулгай, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хуулийн байгууллагаар шалгуулах Эмээлт эко парк, Туулын замын трассын хууль, эрх зүйн үндэслэлд нийслэлээс 80 орчим компани байгуулсан. Эрх зүйн үндэслэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр төр хувийн хэвшлээр гүйцэтгэх боломжтой ажлыг компани байгуулан ажиллаж байгаа талаар төлөөлөгчдийн ашиг сонирхлын зөрчил, цаашид үүнийг хэрхэн шийдвэрлэх талаар мэдээллийн ил тод байдал, Сэлбэ дэд төвийг 100 хувь нийслэлийн бондоор санхүүжүүлж буй шалтгаан, хашлага, бродьюр байнга сольж байгаа асуудал, авто замын засвар, стандарт, СХД-ийн бейсболын талбайн зураг, төсөв, нийслэлээс алдагдалтай төсөв баталж байгаа нөхцөл байдалд ямар дүгнэлт хийж байгаа, нийслэлийн өртөг улсын хувийн хэвшлээс өндөр болох шалтгаан, тогтолцооны гажуудал, сонгуулийн тогтолцооны холимог систем, хотын даргыг иргэдээс шууд сонгох иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бие даасан байдал, 16 төслийн бодлогын баримт бичигтэй уялдсан уялдаа, нийслэлийн онцгой статус, засаг захиргааны шинэчлэл, магадлалын зөрөө, аудитын дүн, зам

тээврийн бодлоготой уялдаагүй. Яагаад өмнө нь дүгнэлтээр илрээгүй Сэлбэ дэд төвийн өртөг магадлал хийдэг журам, барилгын тендер, Монгол аж ахуйн нэгжүүдийн оролцоо, 20 минутын хот ба Туулын замын логик уялдаа, 500 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн бодит зарцуулалт, эргэн авах болон захиалагчийн хяналт, утаа түгжрэлийг хэмжих нэгж аргачлал, 16 төсөл тус бүр хэдэн нэгжээр бууруулах эрэмбэлэлт, Туулын зам, Сэлбэ төслийн хэрэгжилт, хяналт, хариуцлагын асуудал, Засаглал, төсвийн бодлого нийслэлийн статус бэлтгэлгүй реформын эрсдэл, Үндсэн хуулийн нутгийн өөрөө удирдах ёсны заалтууд эрх мэдэл өгчхөөд буцаан татах, эсэх урьдчилгаа төлбөрийн эрх зүйн орчин, археологи, палеонтологи, угсаатны судалгааны араас нь хийсэн эсэх, улс ба нийслэл орон нутгийн төсвийн тэгш бус хуваарилалт, реформын шинэчлэл хийх шаардлагатай зэрэг асуудлын талаар дурдаж, холбогдох байгууллага, албан тушаалтнаас хариулт авсан.

Мөн дэгийн дагуу Улсын Их Хурлын 11 гишүүн үг хэлсэн байна.

Ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн дүгнэлт:

1.Нийслэлийн төсвийн тогтвортой байдал алдагдах эрсдэл нэмэгдсэн байна.

Нийслэлийн төсвийн алдагдал улсын нэгдсэн төсвийн алдагдлаас давсан, жилд 4-5 удаа тодотгол хийж байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсвийн сахилга бат, алдагдалгүй төсөв батлах зарчимтай нийцэхгүй байна. Үнэт цаас, бонд болон гадаад эх үүсвэрээр санхүүжүүлж буй төслүүдийн эргэн төлөлт нь цаашид улсын болон нийслэлийн төсөвт нэмэлт дарамт учруулах эрсдэлтэй байна.

2.Хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийн төлөвлөлт, бэлтгэл ажил хангалтгүй байна. Сонсголын үеэр хэлэлцсэн 16 мега төслийн нийт өртөг 28,9 их наяд төгрөгт хүрсэн боловч санхүүгийн гүйцэтгэл ердөө 5 хувьтай байна. Төсөл, арга хэмжээнүүдийн зарим нь ТЭЗҮ, зураг төсөл, газрын асуудал, техникийн магадлал, байгаль орчны үнэлгээ, олон нийтийн оролцооны шаардлагыг бүрэн хангаагүй байхад батлагдсан нь хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах нөхцөлийг бүрдүүлжээ.

3.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд ноцтой зөрчил илэрсэн байна. Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын эсрэг хууль болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хууль тогтоомжийн шаардлагууд бүрэн хангагдаагүй нөхцөл байдал тогтоогдсон байна.

4.Нийслэлийн өмчит байгууллагын тоо, чиг үүргийн давхардал нэмэгдэж, засаглалын эрсдэл үүссэн байна. Сүүлийн жилүүдэд нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой байгууллагын тоо эрчимтэй өсөж, чиг үүргийн давхардал бий болсон төдийгүй төрийн оролцоог нэмэгдүүлж, хувийн хэвшлийн өрсөлдөөний орон зайг хязгаарлах нөхцөл үүсжээ. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид өмчит байгууллагын удирдлага, ТУЗ-д ажиллаж тухайн байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг хэлэлцэн баталж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх өндөр эрсдэлтэй байна.

5.Иргэдийн оролцоо олон нийтийн хэлэлцүүлэг хангалтгүй байна. Томоохон төсөл, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог бодитой хангаагүй, олон нийтийн хэлэлцүүлгийг шийдвэр гарсны дараа зохион

байгуулсан эсхүл хуульд заасан төлөвлөлтийн сонсголыг зохих журмын дагуу хэрэгжүүлээгүй тохиолдлууд илэрсэн байна.

6.Ил тод байдал, мэдээллийн хүртээмж хангалтгүй байна. Нийслэлийн төсөв, мега төслүүдийн хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэгч байгууллага гэрээ зарцуулалтын талаар мэдээлэл иргэдэд бүрэн нээлттэй биш байгаа нь иргэдийн мэдээлэл авах эрх болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

7.Санхүүжилтийн эх үүсвэрийн бодит эрсдэл өндөр байна. Мега төслүүдийн нийт санхүүжилтийн 54 орчим хувийг гадаад зээл, үнэт цаас болон өрийн хэрэгслээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бол .../минут дуусав/

Н.Наранбаатар: Минут нэмж өгье.

Ж.Золжаргал: Эх үүсвэрүүд баталгаажаагүй.

8.Худалдан авах ажиллагаа болон урьдчилсан санхүүжилттэй холбоотой ноцтой эрсдэлүүд илэрсэн. Тухайлбал, 500 тэрбум төгрөгийн урьдчилгааг эргэлзээтэй баталгаагаар олгосон. 8 хүн яллагдагчаар татагдаж, 3 хүн цагдаад хоригдсон. 2,6 их наяд төгрөгийн гүйлгээ хязгаарлагдсан.

9.Хяналт, хариуцлагын тогтолцооны үр нөлөө хангалтгүй байна. Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжүүд бүрэн хэрэгжихгүй байгаа.

Цаашид авах арга хэмжээний талаар 13 ийм саналыг дүгнэсэн байна. Тэгээд энийг тогтоолын төсөл дээр давтагдах учраас тэнд нь уншъя.

Байнгын хорооны гишүүд ээ,

Ингээд ерөнхий хяналтын сонсголын тайлан, дүгнэлтэд үндэслэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсныг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Н.Наранбаатар: Золжаргал гишүүнд баярлалаа. Одоо тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Түвшин гишүүнээр тасаллаа. Бадамсүрэн гишүүн дэс дарааллаараа.

М.Бадамсүрэн: Зарчмын хувьд бол нийслэл, орон нутгийн хариуцлагатай байхыг бол дэмжиж байгаа. Гэхдээ Монгол Улс бол хуулиар орон нутгийн төсвийн харилцаа, тэгээд бусад асуудлуудыг шийдэж байгаа. Тэгэхээр заавал ийм тогтоол гаргах бол хэрэг байсан уу. Энийг тогтоол санаачлагчаас асууя.

2 дугаарт нь яагаад хамтарсан төсөл орон нутагт улсын хэмжээнд хэрэгжүүлж болохгүй гэж. Бид ерөөсөө бүх юмыг ингээд зааглаад байгаа юм. Тэгээд үр ашигтай бол хамтраад зүтгэнэ шүү дээ. Яагаад болохгүй гэж. Энэ дээр хариулт авъя.

Дараагийнх нь тэр бонд зарцуулах эрх, урьд оны төсвийн үлдэгдлийг дараа ондоо зарцуулах эрх гээд энэ орон нутгийн төсвийн эрх мэдэлтэй холбоотой зүйлийг яагаад ингээд бүхэлд нь хязгаарлах ийм чиглэл өгөхийг санаачилсан юм бол. Орон нутаг гээд 21 аймаг, 330 сум байгаа шүү дээ. Энэ тогтоолын чинь үйлчлэлд хамрагдана шүү дээ. Тэгэхээр бүх юмыг зөвхөн нийслэлээр гэж бас бодож болохгүй

байх. Тэгээд энэ дээр яагаад ингэж орон нутгуудыг оруулсан юм бол гэдгийг бас төсөл санаачлагчаас асууя.

Харин дэмжиж байгаа зүйлүүд байна. Орон нутгийн өмчийн газрыг нэмж байгуулахыг бол хязгаарлах нь зөв. Зарим нэг стратегийн салбар дээр бас төрийн өмчит компани байхыг үгүйсгэхгүй. Цаашдаа дэд бүтэц, хөнгөлөлттэй зээлийн бодлого, төсвийн бодлого, зүйлээр дэмжлэг үзүүлээд, хувийн хэвшлээр л гүйцэтгүүлэх хэрэгтэй. Орон нутагт хог хаягдлыг татан зайлуулах үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшил болон орон нутгийн өмчит байгууллага 2-ын хооронд бол чанарын болоод зохион байгуулалтын хувьд бол ялгаатай байдал байдаг. Ганцхан энэ зорилтыг хэрэгжүүлж чадаагүй нь одоогоос 3, 4 жилийн өмнө Сангийн яам энэ зорилтыг эхлүүлээд, тэгээд орон нутгийн өмчит төрийн өмчит компанийн ажилтан, албан хаагчдын асуудлыг давхар цаашид гарах үр дагаврыг нь болон тэд нарт хувилбар сонголт дараагийн ажиллаж амьдрахад нь санал болгоогүй учраас энэ шинэчлэлийн бодлогоосоо ухарчихсан. Тэрнээс хойш энийг хэрэгжүүлж чадаагүй шүү дээ. Тэгэхээр нөгөө нэг юм хийхдээ дараагийн гарах үр дагаврыг нь хамтад нь тооцоод, тэгээд тэр эрх ашгийг нь хангаад явахгүй бол болохгүй. Одоо АНУ-д тэр төрийн байгууллага албан хаагчдыг цомхотгохдоо сонголт өгсөн шүү дээ. Хувиараа бизнес эрхлэх боломж, тэтгэмж өгөх. Тэгээд энийгээ тооцохгүй ингээд нэг л хатуу шийдвэр гаргачихдаг. Тэгээд тэрний дараа нь ингээд үр дагаврууд нь гараад ирнэ. Тийм учраас энийг бол ингэж шийдэх нь зөв байх. Энийг ингэж найруулж оруулбал ямар вэ.

Ил тод байдал болон тэр нийслэл улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлэхгүй байгаа.../минут дуусав/

Н.Наранбаатар: Хариулъя. Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Одоо ингээд эргээд харсан чинь нийтдээ 28, 29 их наяд төгрөг буюу бараг улсын төсвийн 80, 90-ээд хувьтай дүйцэхүйц хэмжээний нийт үнийн дүнтэй ийм төслүүдийг ирэх хэдхэн жилийн дотор хэрэгжүүлнэ гэчихсэн байдалтай явж байгаа. Тэгээд тэндээс гарч байгаа эрсдэлүүд, алдаанууд нь хүлээн зөвшөөрөгдчихлөө. Тийм ээ. Тэгээд буцаад нөгөө улсынхаа төсөв дээр ямар ачаалал бол ирэх вэ, нөгөө зээлийн, бондын эргэн төлөлт нь бол Засгийн газар баталгаа өгсөн. Засгийн газар нь хариуцна. Тэгээд улсын төсөв дээр ачаалал болж ирнэ. Тэгэхээр нэг талдаа мэдээж энэ чинь орон нутаг өөрөө төсвөө хэрэгжүүлээд хөгжилгүй яах вэ. Нөгөө талдаа тэр үлдэж байгаа үлдэгдлээ орлого гэж аваад, тэгээд бодоод явахаар хиймлээр ингээд худлаа төлөвлөөд, тэр чинь орлого биш шүү дээ. Тэгээд зөндөө их юм хийнэ гэчихсэн нөгөөхөө хийж чадаагүй учраас үлдчихсэн байгаа юмыг худлаа тооцоод, шилжүүлээд яваад байхаар өөрөө өөрсдийгөө хуураад ингээд эрсдэл нь улам томроод яваад байх юм байна. Тэгээд ер нь төсвийн нэгдсэн бодлоготой улс тэр зарцуулагдаагүй үлдсэнийг нь буцааж төвлөрүүлж аваад, тэгээд орон нутгууд хэрэгцээ, шаардлагаар нь хуваарилдаг, иймэрхүү байх нь зүйтэй юм гэсэн санаанууд хүмүүс ярьж л байсан л даа. Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр бол мэдээж энэ чинь хуулийн заалт бол биш. Тэгэхээр тэр төсвийн хуваарилалтыг энэ эрсдэл гараад байгааг нь бүх орон нутгаар байх уу, зөвхөн нийслэлд байх уу гэдгийг судлаад төсвийг боловсруулж өргөн барих эрх бүхий субъект бол Засгийн газар. Үндсэн хуулиар. Тэгэхээр тэр Засгийн газар дээрээ төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь олон талаас нь бодож боловсруулаад, санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн барь гэдэг үндсэн агуулга нь бол тийм л агуулгатай байгаа. Миний зүгээс ийм зүйл хэлэх байна.

Н.Наранбаатар: Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Ер нь бид бол энэ хүрсэн түвшнээсээ бол ухарч болохгүй. Би бол энэ ардчилсан нийгэмд төрж өссөн залуучуудын үзэл бодлыг бол их дэмждэг. Яагаад гэхээр нутгийн удирдах ёсны байгууллагыг бид нар бэхжүүлж байж насанд хүрсэн хүүхдээ бид нар амьдралд өөрөө зөв, аав ээждээ тийм ачаалал өгөхгүйгээр явах энэ боломжийг бид нар бүрдүүлж өгөх ёстой. Тэгэхгүй бүгдийг нь ингээд улс руу татан төвлөрүүлээд байвал бид нарын олж авсан энэ хэвтээ ардчиллын үнэт зүйл гэдэг зүйл алга болно. Харин ч хэвтээ ардчиллын үр дүнд орон нутгууд хөгжихийг бас илүү зорьж тэмүүлэхийг бид нар дэмжих ёстой. Тэгэхгүй бүх юмыг босоо болгож байна шүү дээ. Бүх томилгоо босоо. Тэгээд босоо байгаад, ингээд томилгоо нь Засгийн газар, Их Хурлаасаа хараат байгаад, тэгээд илүү үр дүн хаана илүү гараад байгаа юм. Тэгэхээр энийг бид нар шат шатандаа бодох хэрэгтэй. Энийг бол системийн хувьд харах ёстой.../минут дуусав/

Н.Наранбаатар: Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Нөгөө татварын орлого юмыг нь төвлөрүүлэх гэсэн агуулга санаа бол биш гэж би бодож байгаа. Харин нөгөө төсвийн хяналт, зарцуулалтын сахилга батыг сайжруулах, төлөвлөсөн байдлаар юм нь хийгдээгүй, ажил нь хийгдээгүй. Тэгэхээр тэрийгээ буцааж төвлөрүүлээд, дахиад дараагийнхаа төлөвлөлтөд гаргадаг ийм л алхам юм болов уу л гэж бодож байна.

Н.Наранбаатар: Түвшин гишүүн асуулт асууя. Тэгвэл Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Золжаргал гишүүний энэ ил тод болгох, хариуцлагатай болгох, хувийн хэвшлийг дэмжих гээд энэ бодлогуудыг бол бүрэн дэмжиж байгаа. Гэхдээ миний хувьд аймгийн Засаг даргаар ажиллаж байсны хувьд яг энэ тогтоол гарах юм бол, яг энэ агуулгаараа харах юм энэ 330 сум, 21 аймагт чинь бид нар бол тэндээс хөгжил, хариуцлага нэхэх бол боломжгүй болох гээд байгаа учраас ганцхан нийслэлээр энийг битгий хараарай. 21 аймаг байгаа шүү л гэж хэлэх гээд байгаа юм.

Ер нь орон нутагт эрх мэдэл бол Улсын Их Хурал, Засгийн газартай харьцуулахад бол маш бага шүү дээ. Би бас энийг өөрөө бас аймаг удирдаж ажиллаж байсан хүний хувьд бол мэдэж байгаа. Бид нар маш бага хөрөнгөөр их зүйл хийхийг зорьдог. Энд улсын төсөв батлахдаа энэ Засгийн газар төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа аймаар топ 100 хувь сайн байна гэж бол би хэлэхгүй. Энд ирээд мэдсэн зүйл бол орон нутаг төсөв их багатай юм байна. Харин улс төсвийг бол яг хэрэгтэй зүйлдээ зөв эрэмбээр нь зарцуулахдаа учир дутагдалтай юм байна гэдгийг би бол олж дүгнэсэн.

Н.Наранбаатар: Үг хэллээ. Түвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Түвшин: Баярлалаа. Энэ танилцуулгууд, ерөнхийдөө энэ хийсэн ажлуудад сэтгэл хангалуун байна. Ер нь бид нар аль нэгэн орон нутгийнхаа нэгж дээр бас хааяа хяналт тавьж байхгүй бол улсынхаа төсвийн 80, 90 хувьтай өр зээл тавих, энэ олон хэтэрхий олон мега төслүүд тавиад улсынхаа эдийн засгийг ч гэсэн эрсдэлд оруулж магадгүй ийм нөхцөл байдлууд бас үүсэж байна.

Зүгээр урьд нь нийслэлийг бас энэ олон 24 мега төсөл гээд танилцуулж байхад нь хэлж л байсан юм. Ер нь жилд 2-3 мега төслөөс илүү л явах юм бол манай төсвийн ачаалалд бас хэцүү. Орон нутгийн төсөвт ч бас хэцүү. Ер нь эдийн засгийн нөхцөл байдалд ч гэсэн бас хүндээр тусна гэдгийг хэлж байсан юм байгаа юм. Тэгээд 2 гуравхан асуулт асууя.

Ер нь энэ 900 тэрбум төгрөгийн зураг төсөв яагаад 1,9 их наяд болчхов. Тэгээд гуравхан сарын дотор өсчихсөн гээд биччихсэн байгаа юм. Энэ үнэн юм уу. Энэ ер нь яг юу болсон юм. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Одоо ер нь зөвхөн нийслэлд гэхгүй аль ч орон нутаг ийм хэмжээний өр зээл тавиад, улсын эдийн засгийг ийм эрсдэлд оруулах энэ нөхцөл байдлыг ер нь цаашид нь яаж шийдье гэж бодож байна. Ер нь ганцхан энэ орон нутаг ч гэлтгүй улсын төсөв дээр ч гэсэн төсвийн огцом өсөлтүүд их яригддаг. Энэ асуудлыг ер нь юу гэж дүгнэв гэдэг ийм асуудал байна.

3 дугаарт энэ босоо, хэвтээ удирдлагын тухай ярьж л байна л даа. Энийг хослуулах тухай бид нар ер нь ойлголцол багатай л байгаад байна. Ер нь бол хэвтээ удирдлага буюу орон нутгийн удирдлага гэдэг чинь яг функциональ буюу газар дээр нь удирдана. Босоо удирдлага бол дивизинал буюу чиг үүргийн дагуу л удирдана. Энэ 2-ын хослол явж байж л энэ менежмент хэрэгжинэ үү гэхээс биш дангаараа босоо бүгдээрээ мэддэг, эсвэл дангаараа хэвтээ бүгдээрээ орон нутаг мэддэг байж болохгүй шүү дээ. Тэгээд энэ менежментийн функциональ болон дивизинал бүтцээр шийдвэр гаргаж явах энэ чиг үүргийг одоо бид нар яг энэ Засгийн газар дээрээ ч гэсэн хэрэгжүүлэхгүй бол саяхан ч гэсэн орон нутгийн эрх мэдлийг хэт их нэмэгдүүлэх гэлээ. Дангаараа босоо байна энэ тэр гэсэн яриа гарч л байх шиг байна лээ. Тэгэхлээр ер нь энэ цаашдаа хэт олон мега төслүүд болох энэ эдийн засгийн үр ашиггүй ч юм уу, магадгүй гадаад дотоодын хөрөнгө оруулагчаар ажлаа гүйцэтгэж байгаа энэ төслүүд бусад газруудад явагдах эрсдэлтэй байна. Энэ ер нь нээлттэй байгаа юм байна. Энийг тэгээд яаж хязгаарлах вэ. Нөгөө талаас орон нутгийн өөрөө өөрийгөө мэддэг энэ эрх мэдлийг нь хязгаарлахгүйгээр ямар шийдэл оруулж ирж байгаа вэ гэдгийг асууя.

Н.Наранбаатар: Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Би эхний асуултад хариулъя. 2024 онд тэр Туулын хурдны замын төсөл 916 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар зураг, төсөл нь хийгдээд, магадлан хийгдээд, бэлэн болчихсон байсан юм билээ. 2024 оны 11 сард. Тэгээд Засгийн газраас Ерөнхий сайдаас чиглэл өгөөд, Зам, тээврийн сайд, нийслэлийн Засаг дарга нар үүрэг даалгавар өгөөд урьдчилсан ТЭЗҮ боловсруулаад 6 эгнээтэй болгож, өргөн болгоод, тэгээд өргөн болгочихоор урьдчилсан ТЭЗҮ-ээр үнийн дүн нь 1,9 их наяд болж нэмэгдэж орж ирсэн. Ажлын хэмжээ нэмэгдсэн гэсэн үг. Тэгээд ТЭЗҮ, урьдчилан .../минут дуусав/

Н.Наранбаатар: Одоо төсвийн зохицуулалттай холбоотой асуултад нь Сангийн яам хариулна. Индрийн микрофон дээр хариулах ёстой.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Сонсгол дээр Сангийн яамнаас төлөөлж, 2 өдрийн сонсголд суусан. Тэгээд техник талаас нь асуулт гарвал хариулаарай гэдэг чиглэл өгсөн учраас ирчихсэн байгаа. Тэрнээс тогтоолын төсөл дээр бид яг бас юунд нь ороогүй байгаа.

Төсвийн зохицуулалтын хүрээнд бид бол илүү том утгаар нь саяын энэ тогтоолыг бол харлаа. Тэгээд Засгийн газарт чиглэл өгчхөж байгаа учраас бид энэ дагуу орж ирсэн тохиолдолд ямар байдлаар ажиллах вэ гэдгийг харлаа. Яах вэ, том агуулгаараа бол мэдээж хэрэг нэгдсэн төсвийн бодлогын асуудал явж байгаа учраас нийслэлийг дангаар нь сугалж авч ярингуутаа бусад аймгуудыг бас үлдээж ярихад бас зохимжгүй байж магадгүй гэж бид харж байна.

Н.Наранбаатар: Нэмж минут өгье.

М.Санжаадорж: 2 дугаарт болохоороо төсвийн орлогын хуваарилалтаасаа илүү бас зарлагын хуваарилалт дээр энэ тогтоолоор бас үүрэг өгч байгаа юм гэж ойлголоо. Энэ дээр зарим төвлөрсөн тэр зардлууд, чиг үүргүүдийг бол орон нутаг руу нь намрын төсөвтэй холбоотойгоор хэрвээ энэ тогтоол гарах юм бол бид оруулж ирэх юм байна гэж бас ойлголоо.

Мөн үүнтэй холбоотойгоор бас орлогын хуваарилалтын асуудал орж ирнэ. Тэгэхээр нөгөө төсвийн яг энэ хуваарилалтын асуудлууд бол орж ирэх юм байна гэж харлаа.

Тогтоолын төслийн тэр ар дээр нь байгаа тэр “ж”, тэгээд өмнөх дээр нь байгаа Улаанбаатар хотын энэ чиг үүрэг, нийслэлийн чиг үүргийн давхардал гээд энэ хэсгүүд ороод ирчихээр ерөнхийдөө яг аль чиг үүргүүд нь нийслэлээс, аль чиг үүргүүд нь улсаас байх вэ гэдэг дээр явах ёстой гэж бол харж байна. Ер нь зүгээр Засгийн газрын хувьд орон нутаг руу илүү төсвийн эрх мэдлийг шилжүүлэх .../минут дуусав/

Н.Наранбаатар: Тодруулах уу. Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Гол асуугаад байгаа зүйлийн хариултаа авч чадахгүй л байгаад байна л даа. Энэ 24 мега төсөл бол олон гэдгийг бүгдээрээ л зөвшөөрч байгаа шүү дээ. Хэтэрхий том дүнтэй, хэтэрхий олон байна. Гэхдээ орон нутаг өөрөө хөрөнгө санхүүжилт босгоод, тодорхой хэмжээний ийм томоохон төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой. Тэгээд энэ 2-ын дээд хязгаарыг яаж тогтоох юм бэ гэдэг асуултад л Сангийн яамыг хариулаад өгөөч гэж байгаа. Цаашдаа ерөөсөө ийм асуудлууд гарна шүү дээ. Бид нар бүх орон нутгийг хөрөнгө оруулалт хийхийг нь зогсоогоод, санхүүжилт мөнгө босгохыг нь зогсоочих юм бол цаашдаа хэтэрхий төвлөрөөд явчихна. Орон нутаг чинь өөрөө эдийн засгийн хувьд бие даах, юм хийх боломжгүй болчихно шүү дээ. Тэгэхдээ ямар хэмжээнд байх юм. Сая улсын төсвийн 90 гаруй хувьтай байх, алдагдал нь улсын төсвөөс давсан байна гэж байгаа бол хэтэрсэн л асуудал яригдаж байна. Энэний зохистой харьцааны тухай Сангийн яам надад тодорхой хариулт өгөөдхөөч.

Н.Наранбаатар: Сангийн яам. Индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Тэгэхээр зохистой харьцааны асуудал болохлоор энэ тогтоолоор бас илүү тодорхой гарч ирэх юм байна гэж ойлгоод байгаа. 2022 оны гол нөгөө Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үндсэн концепц бол орон нутагтаа илүү эрх мэдэл өгөх байсан. Гэхдээ бас яг сонсгол дээр Сангийн сайд бас танилцуулга хийсэн. Чиг үүрэг нь хаана очоод зогсож байна гэдэг нь л тодорхойгүй байгаад байгаа юм. Жишээ нь, замын асуудал байлаа гэхэд явган хүний замыг нийслэл ч хийж болж байна. Дүүрэг ч хийж болж байна. Улсын төсвөөс ч бараг хийж болж байна. Нөгөө талдаа

болохоор улсын хэмжээний замыг бас аль аль талдаа хийж болчихоод байгаа учраас энийг илүү тодорхой болгох, тэгэхдээ мөнгөн дүнгээр хязгаарлах уу эсвэл юу гэдэг юм масштабаар хязгаарлах уу, хугацааны хувьд тийм хугацаатайг хязгаарлах уу гэдэг дээр яг олон улсын жишээг үзэж байж манай жишээн дээр хэр ойлгомжтой вэ гэдэг зүйлээс нь харж байж зөв, бурууг нь ярихгүй бол миний хувьд яг одоо танд яг ийм байдлаар ингээд хязгаарлана. Нийслэлийг ингэнэ гэдэг байдлаар бол хэлэх боломжгүй болчихоод байгаа юм. Аль болох илүү их..../минут дуусав/

Н.Наранбаатар: Түвшин гишүүн эхлээд тодруулаад, дараа нь.

Б.Түвшин: Тэгэхээ эндээс ер нь Санжаадорж дарга буюу энэ Сангийн яамныханд ер нь маш тодорхой даалгавар өгөгдөж байна шүү дээ. Яг энэ орон нутгийн төсвийн авах санхүүжилт, босгох мөнгө, хийх хөрөнгө оруулалт нь хэр хэмжээтэй байх юм бэ гэдгийг тогтоож өгөхгүй бол одоо энэ нийслэл дээр гарсан шиг 24 мега төсөл хамаагүй их мөнгө босгоод явчих юм бол бид нар өөрөө улсын төсвөөрөө эрсдэлд орохоор эрсдэлтэй байна. Нөгөө талаасаа хийсэн болгоны шүүмжлэлийг зогсоогоод, хэтэрхий босоо бас болгож болохгүй. Үүний зохистой харьцааг олж, тодорхой бодлого шийдвэр гаргах хэрэгтэй. Ийм бодлого шийдвэр огт байхгүй байгаагаас болж бас энэ асуудал үүссэн байна гэдгийг ойлгож байгаа учраас Сангийн яам өөрөө энэ дээрээ тодорхой бодлого боловсруулж ажиллах ёстой шүү гэдгийг даалгавар болгож өгөх нь зүйтэй байх.

Н.Наранбаатар: Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Саяын Түвшин гишүүний хэлдэг дээр энэ тогтоолын төслийн “б” “в” “г” дээр жишээ нь төсөвт ачаалал үүсэх эрсдэлийг бууруулахын тулд тэр орон нутгийн гаргаж байгаа үнэт цаасны хэмжээ, зориулалт, зарцуулалт, хүүгийн түвшнийг хянах тогтолцоог боловсруулах гээд яг тэг, ингэ тэдэн хувь гэж болохгүй учраас энийг бодож боловсруулаад, буцааж өргөн барь гэсэн агуулгатай. Төслийн онцлогоос хамаараад улсын болон орон нутгийн түвшинд ангилан хэрэгжүүлдэг ийм тогтолцоог бүрдүүлэх талаар. Тэгээд улсын болон нийслэлийн төсвөөр санхүүжүүлэх чиг үүрэг, төсөв, төсөл хөтөлбөрүүдийн зааг ялгаа энийг хэрхэн илүү тодорхой болгох вэ. Энэ одоо байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт дунд нь ингээд илэрхий бас нэг зөрүү гараад байна л даа. Зөрчил үүсээд байна. Тэгэхээр энийг боловсронгуй болгох саналыг Засгийн газар боловсруулж Их Хуралд танилцуул гэсэн тийм үндсэн агуулгатай юм байгаа юм. Тэгээд тэр өмнөх оны үлдэгдлийн талаар ерөнхийдөө бол боломж олдсон дээр ингээд ахиухан авчихъя. Тэгээд энэ авчихсан байж байгаад энийгээ зарцуулж амжихгүй бол тэгээд дараагийнх руугаа яагаад болно биз гэхээр чинь нөгөө авсан мөнгөө зориулалтаар нь хэрэглэхгүй банканд аваачиж тавьж хүү аваад тэр хүүг нь дахиад энүүгээр хүүгээр гудамж тохижуулдаг ч гэдэг юм уу ингээд зориулалтын бус нөгөө сахилга бат нь байхгүй болж таарна. Тэрнийх нь ард дахиад л алдаа гаргах, зардал өсөх, хүүгийн зардал нь өсөх иймэрхүү юмнууд ингээд л гараад байгаа л юм билээ л дээ.

Тийм болохоор миний харж байгаагаар бол орон нутгийн удирдлагыг хэт босоо болгож байгаа зүйл бол биш. Зүгээр төлөвлөсний дагуу сахилга баттай, тодорхой, зориулалтаар нь эх үүсвэрээ ашигладаг байх гэдэг рүү л чиглэсэн ийм санал гэж үзэж байна.

Н.Наранбаатар: Одоо бол бид нар энэ тайлантай холбогдуулж асуулт, үг хэлж байгаа юм. Энэ дуусахаар тогтоолын төсөлтэй холбогдуулаад ахиад асуулт, үг байгаа шүү. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: 1 дүгээрт энэ дөнгөж сая тараагдлаа. Танилцах боломж олгосонгүй.

2 дугаарт энэ хаанаас орж ирж байгаа тайлан бэ. Тогтоол вэ. Ажлын хэсэг хуралдаагүй. Энэ Золжаргал гэдэг хүн өөрөө оруулж ирж байгаа тайлан уу. Би энэ асуудлуудыг, сонсгол хийж байгаа асуудлыг ерөөсөө үгүйсгэхгүй байгаа. Ном журмаар нь хиймээр байна Золоо. Чи ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийг шинжээчээр тавьчхаад, зориуд худал дүгнэлт гаргаад ингээд байж байгаа. Зөв үнээр гаргаад ингээд явчих л байсан асуудал. Заавал тэр тендерт нь орж унасан үнээр шинжээч хийлгээд ингээд ийм юмаар явж болохгүй байхгүй юу даа. 1 дүгээрт.

2 дугаарт энэ асуудлуудыг бас гишүүдийн хэлээд байгаа зүйлийг нь ойлго. Ер нь яах гээд байгаа бол зөвхөн нийслэлд зориулж гарга. Тэгээд энэ төсвийн бодлого дээрээ төсвийн орлогын хуваарилалт, зарлагын тэр боломжуудыг зохистой хэмжээнд байлгах энэ асуудал дээрээ хүн амын тоогоо бодоорой. Анх энийг чинь ингэж л явсан. Улаанбаатар угаасаа аж ахуйн нэгжийн төвлөрөл байгаад хүн амын 50 хувь байгаа шүү. Энэ хэмжээгээрээ угаасаа л тодорхой хэмжээний орлого, төсөв нь ингэж томорч ирнэ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын буцаалт 40 хувь, Хүн амын орлогын татвар чинь энд орж ирж байгаа биз дээ. Хүн амынхаа тоогоор угаасаа л явж байгаа. Тэгээд бүгдийг нь улсын төсөв хурааж аваад энэ асуудлыг шийдүүлэхгүй, 21 аймаг тараах юм бол энэ Улаанбаатарын 30 жилийн зовлон чинь дахиад 60 жилийн зовлон болно шүү. Ийм их амархан юм яриад байгаа байхгүй юу.

Үнэндээ хэлэхэд улсын төсвөөс нийслэлийн бүрдүүлсэн орлогын ерөөсөө 7 хувийг өгдөг байсан шүү дээ. Тэгээд урсгал зардалдаа л таардаг байсан. Тэгээд ийм зүйлүүдийг эргэж буцна, орон нутаг ерөөсөө юу ч хэрэгжүүлж болохгүй гэх юм бол их хэцүү юм даа. Уг нь Түвшин гишүүний хэлээд байгаа зарчим бол зөв шүү. Юмны балансаа олох. Тэгэхээр энэ дээрээ бас анхаараач ээ.

Тэгээд ер нь аливаа асуудал дээр төрийн үйлчилгээг хүн амд, иргэддээ зориулж байгаа бол иргэдийн бас тооноосоо шалтгаалж энэ төсвийн бодлого чинь явах ёстой шүү. Энийг ингээд энэ Золжаргал гэдэг хүн үгүйсгэчихсэн ингээд давхиж байгаа байхгүй юу.

Тэгээд 2 дугаарт энэ зориудаар ашиг сонирхолтой хүмүүс шинжээч оруулж ирлээ. Тайлан мэдээгээ гаргаагүй байж байж баримтыг нь барьчихсан зурагтаар яриад сууж байгаа юм. Энийг тодорхой процесстой байдаг юм шүү Золжаргал аа. Чи ерөөсөө алхам тутамдаа хууль зөрчиж байгаа. Энэ мэдээлэл нуугаад байх юм байхгүй бүгдийг нь тавих ёстой. Тэгэхдээ чи одоогоор ингэж хувийн зорилгоор, телевизээр харуулж болдоггүй юм. Чи хууль зөрчөөд байна. Чи ажлын хэсгийг хуралдуулаагүй. Энэ ажлын хэсгийг хуралдуулаагүй байж байхад тайлан хаанаас орж ирсэн юм. Одоо тэгвэл ажлын хэсгийн санал, дүгнэлт дээр буюу гарын үсэг зураад ч юм уу хуралдсан тэр протоколыг нь олоод ир. Байхгүй шүү дээ. Хаана байна. Ийм юмыг Наранбаатар дарга аа, хэлэлцүүлбэл та өөрөө дэг зөрчиж, Үндсэн хуулийн цэц дээр дуудагдана. Энийгээ даруй зогсоогоод, Золжаргал өнөөдөртөө багтаагаад, тэр ажлын хэсэг энэ тэрээ хуралдуул аа. Чи ингэж хууль зөрчиж болохгүй за юу .../минут дуусав/

Н.Наранбаатар: 1 минутыг нь нэмээд өгчихье.

П.Сайнзориг: Яг хариулахад бэлдэж байгаач. Орон нутаг хэзээ ч төсвийн хуулиар алдагдалтай төсөв батлах боломжгүй байгаа. Яагаад алдагдалтай гээд

худлаа яриад байгаа юм бэ. Энэ тохируулга чинь 2011 оноос хойш явж байгаа. Үнэхээр тэр өмнө жил зарцуулаагүй юмнуудыгаа асуудал байсан бол энийгээ зөв тайлбарла. 21 аймаг болоод нийслэл ямар ч алдагдалгүй байгаа. Дээрээс нь 28 их наяд төгрөгийг төсөвт хэрэгжүүлэх гэж байна гээд айлгаад байгаа боловч энэ чинь том төслүүдийн хувьд бэлтгэл үе шатаараа аль нь ямар үе шаттай явах вэ гээд энэ жил жилийнхээ төсвийн ачаалалдаа хуваагдаад л явна. Тэгээд энийг зориулах гэж байгаа бол зөвхөн нийслэлд гаргаарай. Тэгэхгүй бол дараа дараагийн Дорноговь байдаг юм уу, Өмнөговь байдаг юм уу, Эрдэнэт, Орхон байдаг юм уу, эд нар чинь ингээд бүх юм нь зогсох гээд байна шүү. Би нийслэлийг хамгаалаад байгаа юм биш. Энэ орон нутагт бас юмыг нь хийж өгч, хариуцуулаад хийлгэж сурах хэрэгтэй. Тийм учраас энийгээ шулуухан тэр зарим зүйлүүдээ ингэж гарга. Тэгээд яагаад алдагдалтай гэж худлаа мессеж өгөөд байгаа юм бэ. Зүгээр зохистой харьцааны асуудлыг бол хэн ч үгүйсгээгүй шүү дээ. Яахаар .../минут дуусав/

Н.Наранбаатар: Золжаргал гишүүн эхлээд, дараа нь Сангийн яам.

Ж.Золжаргал: Сонсгол 2 өдөр болж өнгөрсөн. Сонсголын бэлтгэл ажлыг Төсвийн байнгын хорооноос тогтоолоор томилогдсон ажлын хэсэг амжилттай хийж гүйцэтгэсэн. Ажлын хэсгийн ажил бол дууссан. Сонсголын бэлтгэл ажлын хүрээнд шинжээч нарыг Төсвийн байнгын хорооны хурлын тогтоолоор томилж, ажилд оруулсан. Шинжээч нар ажлаа хийсэн. Би бол амжилттай хийсэн гэж үзэж байгаа. Шинжээч гэдэг бол мэдээллийн 1 л эх үүсвэр. Шинжээч энэ талд, нөгөө талд иргэд, энд төрийн байгууллагууд, тэгээд Улсын Их Хурлын гишүүд. Тэгэхээр ингээд өөр өөрийнхөө өнцгөөр бүгд үзэл бодол, байр суурь, мэдээллээ хуваалцсан. Хэн нэгэн хүний хэлсэн үгээр бүх асуудлыг ийм туйлын үнэн юм гэж хэлэх зорилго шинжээчид ч байхгүй, энэ сонсголд ч байхгүй. Хамгийн гол нь хүмүүст мэдээллийг нь бүгдийг нь хүргэх ёстой. Хүргэсэн мэдээлэл нь миний одоо бий болсон итгэл үнэмшлээр бол үнэн байсан, зөв байсан, олж авах боломжтой бүх мэдээллийг богино хугацаанд аль болохоор бүрэн дүүрэн олж авч, амжаагүйг нь араас нь бас олж авч, олон нийтэд хүргэсэн байгаа. Энэ өнөөдрийн тов хурлын хувьд бол Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр авч хэлэлцээд, тогтоолын төслийг өнөөдөр хэлэлцэхээр “баасан” гарагт хэрвээ Төсвийн байнгын хороогоор дэмжигдвэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэхээр даргын зөвлөлийн тов дараалалд орсон байгаа. Ингээд энэ тайланг бол Улсын Их Хурлын Тамгын газар, Хяналт шинжилгээний хэлтэс, Төсвийн байнгын хороо ингээд ажлын албаны хүрээнд, сонсгол даргалагчийн оролцоотойгоор боловсруулсан. Бүх зүйл хуулийн дагуу явж байгаа шүү.

Н.Наранбаатар: Сангийн яам. Индрийн микрофон өгөөрэй.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Одоо манай улс төсвийн хувьд бол мөнгөн суурьтай төсөв явж байгаа. Тухайн жилдээ олсон орлого нь нэг талдаа аваад, нөгөө талдаа гарч байгаа зарлагаа тавиад. Хэрвээ олж байгаа орлогоосоо зарлага нь давсан байх юм бол энийг алдагдал гэж нэрлэдэг. Нийслэлийн хувьд болон орон нутгийн хувьд хуулийн ямар заалт үйлчилж байна гэхээр Төсвийн тухай хуулийн 57.2 дээр алдагдалгүй төсөв батална гэсэн заалт байгаа. Доор нь бол яг дараалаад 57.3 дээр юу гэж заасан байна гэхээр урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг бас нэмэгдүүлж зарцуулж болно гэдэг ийм агуулгатай заалт байгаад байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл 2025 оны орлогыг олсон орлогоо орлого, зарлагаар нь ингээд тооцож гаргаж ирчхээд, 2025 оны орлогоо дахиад 2026 ондоо орлого л гэж дахиж 2 удаа бүртгэдэггүй юм бол энэ өөрөө эх үүсвэрээрээ алдагдалтай төсөв болчихоод байгаа юм. 1 дүгээрт.

2 дугаарт бонд гаргаад явчхаж байгаа. Бонд бол өөрөө өр. Манайх бонд өрийг .../минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцгээж хариулъя.

М.Санжаадорж: Өрийг өр гэдгээр л бүртгэгдгээс биш өрийг бид нар орлого гэж бүртгэдэггүй. Тэгэхээр энэ өөрөө бол алдагдал болчихоод байгаа юм. Хэрвээ аж ахуйн нэгж, байгууллагын хувьд байх юм бол энэ арай өөр хэрэг болно. Мэдээж хэрэг. Эх үүсвэр талаасаа яривал гэсэн үг шүү дээ. Өөрөөр хэлбэл дансан дахь мөнгө нь хэдэн төгрөг байна, энүүгээрээ бид нар юу зарцуулах гэж байна гээд мөргөж байгаа асуудал байх юм бол энэ магадгүй өөр асуудал. Бид төсвийн хууль маань юу гэж явдаг вэ гэхээр жил бүрийн орлогоо тооцоод, зарлагаа тооцоод ингээд алдагдал, тэнцлээ гаргадаг. Тэгэнгүүт ноднингийнхоо орлогыг дахиад дараа жилд нь орлогоо гэж хэлээд ингээд тэнцлээ гаргах юм бол ганцхан зөвхөн нийслэл дээр өөр зарчим үйлчлэх болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас бид нар энийг заавал авч үзэхийн тулд нэгдсэн төсвөөр авах нь зүйтэй гэж үзээд байна.

Тэгээд энэ тогтоолын төслийн 1 дээр болон 2 дээр яг энэ агуулгаар холбогдох арга хэмжээг судалж шинэчлээд илүү боловсронгуй болго гэхихсэн заалт тавьчихсан байгаа юм байна. Тэгээд энэ дагуу бид нар ажиллах нь зүйтэй л гэсэн ийм бодолтой байна.

Н.Наранбаатар: Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж болно гээд байгуулсан. Тэгээд сонсгол даргалагчийн эрх, үүрэг гээд энэ Дэгийн тухай хууль дээр сонсголын тайланг хянаж, эрх бүхий этгээдэд танилцуулах гээд ийм дэгээр л явж байгаа юм байна шүү. Бусдаар хууль зөрчөөд байсан юм бол байхгүй. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгэхээр цаашдаа Сангийн яам маань одоо энэнээсээ ухарч байгаа юм байна. Анх 2 жилийн өмнө төсвийн реформыг хийж байхдаа бид хэд нийслэл, орон нутгийн түвшинд хариуцах юман дээр улсын төсөвт тавихгүй гэсэн. Улс төрчдийнх нь ногоон, улаан лааз өргөж байгаад бүгдийг нь тавьсан та нар өөрсдөө. Тэгэхээр үгүй ээ, үгүй энэ хязгаартай байхгүй юу. Уг нь энэ хуулиараа хийчихсэн. Тэгэхээр юу хэлэх гээд байна гэхээр зам гэдэг чиг үүргийг та нар өөрөө нэгжийн хууль дээр тавиулсан шүү дээ. Замдаа ингээд оролцохгүй, сургуулиудыг оролцохгүй гээд. Тэгээд гишүүд нь ингэж тавиад, холилдоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ нэгмөсөн гарга.

2 дугаарт үнэ өртгөөсөө байдаг юм уу, тэдэн 100 тэрбумаас дээшээ бол эсвэл улсын төсөв дээр суулгаж, яам нь хэрэгжүүлнэ гэдэг зарчмаа гарга. Энэ орон нутгууд чинь ийм хүнд байдалд орчихоод байна шүү дээ. Нэгжийн хуулийнхаа дагуу чиг үүргээ хэрэгжүүлээд, мөнгөө босгосныхоо төлөө ингэж одоо буруутгагддаг зүйл байх юм бол энэ чинь бүтэхгүй. Тэгэхээр энэ дээрээс чинь харагдахгүй байна. Тийм учраас Золоо гишүүн ээ, та хэдийн улс төрийн зорилгыг чинь ойлгож байгаа. Би зүгээр нийслэл гээд гаргаач ээ. Битгий энэ бусад аймгууд .../минут дуусав/

Н.Наранбаатар: Асуулт асуугаагүй гэж байна. Булгантуяа гишүүн алга байна. Батжаргал гишүүн алга байна. Гишүүд асуулт асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120.5-д “энэ хуулийн 120.1, 120.2-т заасан сонсголыг Байнгын хороо явуулсан бол сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр Байнгын хорооны санал, дүгнэлтэд

тусган нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.” гэж заасны дагуу Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн талаарх ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах асуудлыг санал нэгтгэйгээр шийдвэрлэнэ. Санал хураалт явуулах юм байна шүү дээ. Гишүүдээ дуудаарай. Ийм дэг байхгүй. Санал хураалт одоо явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Төсвийн байнгын хорооны гишүүд танхимд орж ирээрэй. Санал хураалт явуулна. Санал хураалтад гишүүд бэлтгэж байх хооронд Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн талаарх ерөнхий хяналтын сонсголын тайланг ... энэ санал хураалтын дараа болох юм байна. Дэмжигдсэн тохиолдол. Төсвийн байнгын хорооны гишүүд танхимд орж ирээрэй. Одоо санал хураалт явна. Санал хураалтад бэлтгээрэй. 8 бэлтгэсэн байна шүү дээ. Тэгэхээр хүрэхгүй нь. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. 11 гишүүн бэлтгэсэн байна. Батжаргал гишүүн бэлтгээгүй байна. 12 болсон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120.5-д “энэ хуулийн 120.1, 120.2-т заасан сонсголыг Байнгын хороо явуулсан бол сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусган нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.” гэж заасны дагуу Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн талаарх ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах асуудлыг санал хураалтаар шийдвэрлэнэ. Санал хураалт.

Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн талаарх ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120.6-д “Байнгын хороо сонсголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10.1-д заасан асуудлаар холбогдох тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.” гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10.1-д “Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.” гэж заасны дагуу “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу. Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн, Бадамсүрэн гишүүн дарааллын дагуу, ирцийн дарааллаараа.

М.Бадамсүрэн: Тэгэхээр энэ орон нутаг, 21 аймаг, 330 сум, нийслэл, дүүргүүд гээд энийг төсвийн болон өмчийн томилгооны бодлогоор бол дэмжих нь зүйтэй. Гэхдээ тодорхой бас хяналт, механизмын хувьд, хууль, эрх зүйн хувьд бол сайжруулах хэрэгцээ шаардлага нь байгаа гэж энэ төслийн санаачлагч бол үзэж байгаа юм байна. Тэгэхээр ер нь орон нутгийг бие даалгаж байж энэ дэлгэсэн тэрлэг шиг өргөн уудам нутагтай Монгол Улсын хувьд бол Засгийн газар, Улсын Их Хурал

улсын хэмжээний том бодлогын асуудлаа шийднэ. Тэгэхгүй бол өнөөдөр ингээд орон нутгийн бүх юманд оролцоод байгаа байхгүй юу. Энэ нийслэлээс 2 мянган км-т байгаа, мянган км-т байгаа тэр зүүн, баруун хязгаарын аймгуудын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй шүү дээ. Одоо сүүлдээ бүр ингээд орон нутгийн бүх юманд оролцдог болж байгаа байхгүй юу. Үгүй ээ, уг нь энэ орон нутгууд чинь илүү бие даагаад, сайн явбал улсад л амар баймаар юм. Хэдийгээр нэгдмэл улс ч гэсэн.

Яг үнэндээ боловсролын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, спортын байгууллага, тэгээд энийг бүгдийг нь босоо болгочихсон. Тэгээд энэ удирдаж байгаа сайд нь тэр орон нутаг, аймагт байнга очиж удирдлагаар хангах уу. Аймаг, сумын Засаг дарга бол засаг, төрийн төлөөлөгч байхгүй юу. Хуулиараа. Тэгээд тэр засаг, төрийн төлөөлөгчид нь эрх мэдлийг нь өгөөд, харин хариуцлагыг нь сайн тооцоод явах хэрэгтэй шүү дээ. Тэгээд ажиллаж чадахгүй бол солих эрх нь дээд шатанд нь байна. Тэгэхгүй ингээд нэг газар жоохон асуудал үүсвэл тэгээд л бүхэлд нь болохгүй юм шиг ингэж хандаад байгаа. Тэгээд энэ рүү энэ тогтоолын зарим агуулга ороод байгаа юм.

Тийм учраас би зарчмын хувьд бол зарим зүйл дээр нь дэмжихгүй байгаад байгаа юм. Энийг бүх юм руу нь ингэж нэг бүрчлэн ингэж орохоос илүүтэй, ер нь орон нутгийн төсвийн эрх мэдэлтэй холбоотой, зарим орлого, зарлагатай холбоотой ялгаатай байдлыг арилгах чиглэлээр бас анхаарах ёстой. Тухайлбал, орлого өндөр төвлөрүүлдэг хүн ам төвлөрөн суурьшсан нийслэл болон хэд хэдэн хотын зэрэглэлтэй аймгууд, аймгийн төвийн хотууд орлого нь өндөр байдаг. Гэтэл улсын хэмжээнд бүх аймаг, бүх сумд нь зарлага нь ерөнхийдөө адилхан. Ялгаатай юм бол бага шүү дээ. Тэгээд үүнтэй холбоотой ийм зөрүү гараад байгааг л хууль, эрх зүйн хувьд нь бүхлээр нь харж шинэчлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ ингээд ганцхан нийслэлд чиглэхсэн юм шиг ингэж харагдаад байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Одоо энэ тогтоол гаргаж байгааг бол дэмжиж байгаа. Сая Бадамсүрэн гишүүний хэлж байгаа саналыг ч гэсэн бас дэмжиж хүлээж авч байгаа. Тэгэхдээ сонсгол хийгдсэнээр маш сайн үр дүнд хүрсэн гэж миний хувьд бол үзэж байгаа. 1 нам дангаараа хяналтгүй явахаараа яаж хулгай гардгийг л бид нар бодитойгоороо энэ сонсголоор нотолж харуулсан. 1 нам дангаараа яаж засаглаж яваад, яаж хуулийн хийдэл гарч болдгийг жишээлэхэд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр хийдэл гарч байгааг бид нар олж харж чадсан. Энийг засах ёстой. Тэгээд үргэлжлүүлээд явахаар хийдэл өгөхөөр нөгөө улаан намын цагаан байрныхан яаж хулгай хийж болдгийг бас бид нар тодорхой хэмжээнд харсан. Тэгэхээр үргэлжлүүлээд энэ хулгайтай яг энэ тогтоолтой холбогдуулаад хэлэхэд хулгайтай нэр холбогдож байгаа хүмүүсийг зүгээр халаад, энэ нь хариуцлага юм гээд хий хоосон үлдээж бол болохгүй. Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр бүр яг тодорхой заагаад, хэчнээн төгрөгийн хохирол хэнд учруулсан байна тэрийг нь төлүүлээд, тэгээд холбогдох хуулийнх нь хариуцлагыг хүлээх гэж бүр тодорхой зааж оруулмаар байгаа юм. Энэ дээр чинь ерөөсөө цаашид авах арга хэмжээний санал дээр бол заагаагүй байна лээ. Хэтэрхий ерөнхий явчхаж байгаа юм. Тэгээд миний бодлоор энийг энд зааж оруулах ийм саналтай байгаа. Энэ хулгайг бид нар бага гэхгүй, нийслэл дээр гэхгүй олж авч чадсан юм бол гарах үр дүн нь хэн нэгэн хуулийн хийдэл байна гээд хулгай хийгээд байдаг байдлыг таслан зогсоох ёстой учраас энэ саналыг оруулах ийм санал байгаа юм.

Н.Наранбаатар: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Ингээд ерөнхий байдлаар нь дэмжье гэчихдэг засвар орох юм уу, үгүй юм уу энэ чинь. Хэзээ оруулах юм. Харин оруулах юм бол оруулахаа тов тодорхой болгож янзалмаар байна.

Хэд хэдэн зүйл байгаа юм. Энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчлэлийг хийхдээ бид энэ орон нутгуудын эрх мэдлийг нэмэгдүүлэх, чиг үүргээ хангах хэмжээний эдийн засаг, төсвийн чадамжтай байлгах талаар бодлого барьсан юм. Үр дүнгээ өгч байгаа байхгүй юу. 4 жилийн дараа энэ орон нутгууд чинь хөөрхөн хөрөнгө оруулалт хийдэг болчихсон, энэ асуудлууд нь бас хяналт юм нь сул байгааг харуулсан ийм үр дүнгүүд одоо гарч байгаа байхгүй юу. Нөхцөл байдлууд. Тэгэхээр энэ хуулийн үзэл баримтлалыг тогтвортой барьж хэрэгжүүлж байж орон нутгууд чинь чадамж нь нэмэгдэнэ. Хүнд эрх мэдэл өгөхдөө нөгөө талд нь хяналтынх нь асуудлыг тавьж өгдөг чек балансынх нь асуудлыг тэр нь дутсан байхыг үгүйсгэхгүй. Тэрийгээ л онцгой анхаарах ёстой. Тэрнээс энд нэг ийм юм гарчихлаа гээд энэ орон нутгуудын юмыг хумих гэсэн үзэл санаа илэрхийлдэг эд нараа одоо болих ёстой. Би бол шууд тэгж хэлмээр байна. Дан дамаа нь тэр орон нутгуудын жоохон үлдэж байгаа үлдэгдлийг дараа жилийн эх үүсвэр болгож ашиглахгүй энэ тэр гээд. Тэгээд тэрийг юунд зарцуулах юм, яаж зарцуулах юм, тэр эрх зүйн орчныг нь л тодорхой болгож өгөх ёстой шүү дээ.

2 дахь зүйл орон нутгуудыг бид бонд гаргаж болно гэсэн юм. Ганцхан л юм бий. Өөрөө өөрийгөө санхүүжүүлж байгаа аймгууд гэдэг 1 үг орчихсон юм. Тэрнээс биш эдийн засгийн гэдэг юм уу, төсвийн гэдэг юм уу, ямар үзүүлэлттэй уялдуулж, тэрний ямар түвшинд бонд гаргаж болох юм бэ гэдэг юмыг нарийсгаж хуульчилж өгөөгүй юм. Тийм учраас энэ бонд үнэт цаасныхаа асуудлыг нарийсган зохицуулсан хууль, эрх зүйн орчноо бүрдүүл гэдгийг Засгийн газарт чиглэлийг нь өгөх ёстой. Тэгж байж энэ орон нутгууд чинь цаашаагаа эмх цэгцтэй, зөв явах бололцоо боломж нь бүрдэнэ гэж би бол энэ талаас нь хараад байна. Ийм зүйлүүдээ л оруулмаар байна даа

Н.Наранбаатар: Болно оо. Гишүүд болохоор энд 3 зарчмын зөрүүтэй санал ирүүлчихсэн байна. Ингээд ийм маягаар хэдүүлээ хураагаад өөрчлөлт оруулаад явна. Гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор 4 санал одоогоор ирсэн байна. Дахиад хэнээс ирэх юм. Гялс уншаад дуусгачихъя. Эхнийхийг нь уншихъя. Тогтоолын төслийг та бүхэнд тараагаад өгчихсөн.

1 дээр ийм юу нэмэхээр. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай гэж өөрчлөх. Санал гаргасан Наранбаатар. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад бэлтгээрэй. Санал хураалт. Дэмжье гэсэн томьёоллоор. 55 хувиар дэмжигдлээ.

Дараагийнх нь.

Төслийн 1 дэх заалтын “г” дэд заалтын “зааг ялгаа” гэсний дараа “зохистой харьцаа бий болгох” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувийн саналаар дэмжигдлээ.

Дараагийнх нь. Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дэх дэд заалт нэмэх:

“3/орон нутгийн төсвийн хувьд хөрөнгө санхүүжилт босгох томоохон төсөл хэрэгжүүлэх дээд хязгаарыг хүн ам, газар нутаг, тухайн орон нутгийн төсвийн орлогыг харгалзан тогтоож өгөхийг Засгийн газарт үүрэг болгох.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Түвшин. Санал хураалт. 55 хувиар дэмжигдлээ.

Дараагийнх нь. Орон нутгийн бонд гаргахдаа тухайн орон нутгийн эдийн засаг, төсвийн ямар үндэслэлээр хэдэн хувь тооцож гаргаж байх талаар эрх зүйн ямар юм гэнэ вэ. 1 дүгээр ангийн хүүхэд шиг л юм бичсэн байна. Эрх зүйн орчныг бүрдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батжаргал. Санал хураалт. 50 хувиар дэмжигдсэнгүй.

Хамгийн сүүлийнх Цогтбаатар гишүүн ээ. Тэгвэл Батжаргал гишүүний гаргасан санал Түвшин гишүүнийхтэй агуулга 1 байгаа учраас нэгтгэчихье. Санал хураах билүү, үгүй билүү.

Ажлаас халаад болдог биш юу вэ энэ чинь. Ажлаас халаад болдог биш гаргасан үр дүнгээр нь хариуцлага ярих. Тэр хариуцлага нь тодорхой мөнгөн дүнтэй холбоотой бол хуулийн хариуцлага хүлээлгэхээр хууль, шүүхийн байгууллагаар шийдүүлэхээр хүргүүлэх. Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар. Санал хураалт. 1 үлдчихсэн байна шүү. Байж байгаарай. Дэмжигдсэнгүй шүү дээ. 50 хувиар. Дараагийнх нь тогтоолын төсөл дэх орон нутгийн бонд гэж байгаа юм уу. Орон нутгийн бонд, орон нутаг буюу аймаг, сум гэсэн агуулгатай хэсгүүдийг хасах. Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Санал хураалт. 50 хувиар дэмжигдсэнгүй.

Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн талаарх ерөнхий хяналтын сонсголын тайлан болон нийслэлийн 2024-2026 оны төсвийн асуудлаарх Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулахыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 50 хувиар дэмжигдсэнгүй. Алив 1 гишүүн нь горимын санал гаргаадхаач. Гялс дуудаадах даа. Дахиад горимын санал гаргаад. Тайлан танилцуулна.

Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн талаарх ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Золжаргал танилцуулах уу. Хэн танилцуулах вэ. Энхтүвшин гишүүн танилцуулна.

Ерөнхий хяналтын сонсголын тайлан болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

17.12 цаг.

3 дахь асуудал.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Бат-Эрдэнийн Хулан Сангийн дэд сайд, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Ганболдын Нандинжаргал Үндэсний аудитын газрын Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Пүрэвсүрэнгийн Чанцалдулам Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Ванданы Эрдэнэцогт Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Сүхбаатарын Нацагдорж Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Жаргалсайханы Нямцэцэг Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор, Мөнхбатын Нямсүрэн Сангийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан, бүртгэлийн хэлтсийн дарга, Намдагийн Оюун-Эрдэнэ Сангийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Шаравын Бат-Эрдэнэ Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Нэргүйн Цолмон Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Доржсүрэнгийн Долгорсүрэн Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө орлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалт, удирдлагын арга зүйн газрын дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга гэсэн ийм хүмүүс ажлын хэсэгт байгаа юм байна.

Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн боловсруулж, “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт Засгийн газраас 2026 оны 06 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30 их наяд 303,2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33,7 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34,8 хувьд тус тус хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27,9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ий 1,1 хувьтай тэнцэж байна.

Тайлант онд улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 18 их наяд 988 тэрбум төгрөгт хүрч 95,9 хувийн биелэлттэй, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 20 их наяд 414,3 тэрбум төгрөг буюу 90,5 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 613 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 2 их наяд 135,4 тэрбум төгрөгийн буюу 73 хувийн санхүүжилтийг, гадаадын зээл, тусламжийн хүрээнд 116 төсөл арга хэмжээнд 1 их наяд 874,9 тэрбум төгрөгийн буюу 96 хувийн санхүүжилтийг, нийт 729 төсөл, арга хэмжээнд 4 их наяд 10,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, энэ хүрээнд 1800 орчим аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж ажилласнаар 11 мянган ажлын байрыг хадгалж, улсын хэмжээнд 490 төсөл, барилга байгууламж ашиглалтад орууллаа.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 8.10.2 дахь заалтад тус тус заасны дагуу нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг Төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийлгэн аудит хийлгэн улсын төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг баталгаажуулсан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Н.Наранбаатар: Сангийн сайд баярлалаа. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. Индрийн микрофоныг өгөөрэй.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийснээ тоймлон танилцуулъя.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 183 тайлан нэгтгэгдсэнээс 98 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 67 байгууллага, 18 дансыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 76 байгууллагад өөрчлөлтгүй, 22 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт тус тус өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 418,2 тэрбум төгрөгийн 234 зөрчил илэрснээс 0,1 тэрбум төгрөгийн зөрчилд 25 төлбөрийн акт тогтоож, 46,5 тэрбум төгрөгийн зөрчилд 88 албан шаардлага хүргүүлж, 370,8 тэрбум төгрөгийн зөрчилд 113 зөвлөмж, 0,8 тэрбум төгрөгийн зөрчилд 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 7 албан шаардлага хүргүүлж, 1 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүллээ.

Сангийн сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 138,5 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 74 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөснөөс 77,4 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 60 төсөл, арга хэмжээ 80,1 хувийн биелэлттэй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд 75 хувьтай

байгаа бөгөөд тайлант онд илэрсэн зөрчил нь өмнөх оноос 362,2 тэрбум төгрөг нэмэгдсэн тул Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан шаардлагыг бүрэн хангавал дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар албан шаардлага хүргүүлээ.

Монгол Улсын төсөв, өрийн удирдлага болон макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэл “В+” эерэг байсныг “BB-” тогтвортой, Moody-s агентлаг “B2” тогтвортойгоос “B1” тогтвортой түвшинд 1 шат ахиулж, Fitch агентлагаас “В+” тогтвортой түвшинд хэвээр үнэлэгдэж, улсын зээлжих зэрэглэл болон зээлийн эрсдэлийн үнэлгээ сайжирсан нь Сангийн сайдын тайлант онд хэрэгжүүлсэн онцлох ажлуудын нэг байлаа. Энэ нь улсын эдийн засгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, гадаад хөрөнгө оруулалт, санхүүжилтийн боломжийг өргөжүүлэх эерэг үр дүнг бий болгох боломж гэж харж байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагч 18 их наяд 370,1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 17 их наяд 367,3 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 94,5 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унаж, уул уурхайн салбарын өсөлт саарснаас эдийн засгийн идэвхжил суларч, импорт буурсан зэргээс гаалийн байгууллагын орлого 1 их наяд 65 тэрбум төгрөгөөр тасарсан нь голлон шалтгаалсан байна.

Сангийн сайдын багцын орлогын гүйцэтгэл өмнөх оноос 1 их наяд 540,1 тэрбум төгрөгөөр буурчээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3 их наяд 910,7 тэрбум төгрөг буюу 93,7 хувьтай байгаа нь 8 хөтөлбөрт хамаарах нэн тэргүүнд цалин, НДШ, урсгал шилжүүлэг, татаас, хүүгийн зардал, гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийг санхүүжүүлэхэд нийт зардлын 3 их наяд 874,1 тэрбум төгрөг буюу 95,9 хувийг зарцуулсан боловч санхүүгийн зах зээлийн зохицуулалт хөтөлбөрийн гүйцэтгэл 5,9 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төлөвлөхдөө зорилтот түвшнийг үнэн зөв, бодитой төлөвлөөгүй, хэрэгжих боломжтой арга хэмжээг тусгадаггүй зэргээс төсвийн зардлын гүйцэтгэл, арга хэмжээний зорилтот түвшний үзүүлэлтийн биелэлт уялдахгүй, үр дүнг үнэлэх боломжгүй байдал ажиглагдаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрч байгаа зөрчлийг бууруулах арга хэмжээ авах, зээл тусламжийн ашиглалт, хөрөнгийн менежментийг сайжруулах, захиалагч төсвийн ерөнхийлөн захирагчийн төслийн үйл ажиллагаа, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, хуулиар төсвийн орлого бүрдүүлдэг төсвийн төвлөрүүлэн захирагч нарын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын биелэлтийг хангуулах зэрэг асуудалд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Дээр дурдсан аудитын дүн, дүгнэлтээс үндсэн үндсэн дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн төслийн саналыг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэх, тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, түүнд зарцуулагдах төсвийг үнэн зөв бодитой төлөвлөж хэрэгжүүлэх;

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, үр дүнг үнэлэх үе шат бүрд төсвийн ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлагыг сайжруулах;

3.Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн “Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө гаргах тухай” Засгийн газрын шийдвэрийн төслийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын нөөц сангийн зарцуулалтад хяналт тавих” журмын холбогдох заалтын дагуу хууль тогтоомжийн нийцлийг үндэслэлтэй хянаж шийдвэрлүүлж ажиллах;

4.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс өмнөх оноос санхүүгийн тайлангийн зөрчил 355,9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаад анхаарал хандуулж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

5.Засгийн газрын 2012-2025 оны хооронд 18 хөгжлийн түнш, гадаад улс орнуудын эх үүсвэрээс нийт 32 их наяд 699,4 тэрбум төгрөгийн зээлийн хэлэлцээр байгуулснаас ашиглалт 40,8 хувьтай, зээлийн эрх нээгдсэн 45 төсөл, арга хэмжээний 9 их наяд 109,5 тэрбум төгрөгийн ашиглаагүй зээлийн үлдэгдэлд тайлант онд 37,6 тэрбум төгрөгийн амлалтын хүү төлсөн байх тул гадаад зээлээр санхүүжиж байгаа төсөл, хөтөлбөрийн мөнгөн урсгалыг бодитой төлөвлөж, зээлийн ашиглалт, өрийн менежментийг сайжруулах.

6.Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр олон жил үргэлжилсэн гэрээний хугацаа сунгасан төслүүдэд хэрэгжилт удааширснаас төслийн үр өгөөж буурах, нэмэлт зардал гарах, төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт буурах эзэнгүйдэх эрсдэлтэй байгаа тул төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт төслийн эрсдэлтэй байгаа тул төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт төслийн захиалагч буюу төсвийн ерөнхийлөн захирагчдын тавих хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах;

7.Татварын албаны улсын төсөвт төвлөрүүлбэл зохих 35 тэрбум төгрөгийн татварын хүү, торгуулийн орлого 2025 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл гараагүй байгаад анхаарч, улсын төсвийн орлогыг үнэн зөв бодитой төлөвлөх;

8.Татварын алба нь босоо тогтолцоотой улсын төсвийн байгууллага боловч орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд татварын газар, хэлтсийн үйл ажиллагааг дэмжих, зарим үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зэргээр 28 татварын газар, хэлтэст 4,4 тэрбум төгрөг, нийслэлийн Татварын газар, дүүргүүдийн татварын хэлтэст шат шатны Засаг даргаас авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг бүрдүүлэхэд зориулан 0,6 тэрбум төгрөгийн урсгал зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан нь төсвөөс гадуурх зарцуулалт үүсгэж байгааг таслан зогсоох;

9.Төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрт олгосон эрхийн хүрээнд батлагдсан төсөвт зохицуулалт хийхдээ Сангийн сайдын тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал, зааврыг зөрчиж, бүлгийн дүнгээр хянагдах зардлуудыг бүлэг хооронд гүйлгэн зохицуулалт хийж зарцуулж байгаа тул Сангийн сайдын тушаалаар баталсан төсөвт зохицуулалт хийх журмыг зарцуулалтад хяналт тавих журамтай уялдуулан шинэчлэн сайжруулах;

10.Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд анхаарч, аудитын шийдвэр болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа дүн шинжилгээг хийж, цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн хэрэгжилтэд дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна гэж заасныг бүрэн хангуулж, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Монгол улсын Ерөнхий аудиторт баярлалаа. Одоо Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотойгоор Сангийн сайд болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас, аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын ерөнхий аудитораас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ 133 их наяд төгрөг зөвхөн яг өнөөдрийн байдлаар баланст бүртгэлтэй байгаа дүн. Үнэлгээ хийх юм бол энэ дүн дахиад өснө. Би энэ аудитын дүгнэлт дээрээс тодорхой хэдэн тоонуудыг л хэлж өгье. Анхан шатын баримтын бүрдэл дутуу ажил, гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нийт 14 тэрбум төгрөг. Тэгээд жишээлэхэд НДШ-ийн авлага, Монгол Улсын авлага, дотооддоо үүсгэж байгаа авлага нэгнээсээ нэгэндээ шилжүүлж үүсгээд байгаа авлага нь зөвхөн НДШ дээр жишээлэхэд Эрдэнэт үйлдвэр 175,5, МТЗ 65,7, МИАТ 23,5, Тавантолгой түлш 13,3 тэрбум төгрөгийг НДШ-ийн санд төвлөрүүлчхэж байгаа юм. Мөнгөгүй байна гэхээр нь энэ компаниуд ийм их мөнгө гаргаад өгчихдөг.

Тэгээд жилийн эцсийн хөрөнгө тооллого дээр гэдэг юм уу Монгол Улс эсвэл хөрөнгөө дутуу, буруу бүртгэдэг алдаа 188,8 тэрбум буюу 190 тэрбум төгрөг. Тэгээд хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй, ангилал зөрүүтэй тайлагнасан 542,6 тэрбум төгрөг. Тэгээд энэ өр төлбөртэй холбоотой хэсэг дээр нь энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нэгэндээ дураараа зээл өгдөг. Нэгнээсээ дураараа зээл авдаг. Тэгээд энэ асуудал нь явсаар байгаад жишээлэхэд энэ Тавантолгой төмөр зам, Гашуунсухайт боомтын хил дамнасан төмөр замын төслийн тухай Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн дагуу Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженер, товчоо групп, Эрдэнэс Тавантолгой компанитай байгуулсан гэрээний дагуу авсан санхүүжилтээс шалтгаалж урт хугацаат зээлийн өглөг 262 тэрбум төгрөг гэж байгаа юм. Гэх мэтээр ингээд маш их хариуцлагагүй асуудлууд яригддаг. Тэгээд энэ Сангийн сайдаас асуух гээд байгаа асуулт маань энэ асуудлууд бодитойгоороо гараад байгаа энэ хариуцлагагүй асуудлууд жишээлэхэд Мэндсайхан сайдыг сайд байх хугацаанд яаж сайжрах юм бэ гэдгийг нь асуумаар байгаа юм. Монгол Улсын

сангийн авдрын түлхүүрийг нь атгаад сууж байгаа энэ сайдын үед 133 их наяд төгрөгийн энэ хариуцлагагүй, замбараагүй үрж байгаа энэ асуудлууд яаж шийдэгдэх вэ гэдгийг 1 дүгээрт асуух гэсэн юм.

2 дугаарт нь, тэр 10 аймгийн дулааны станцын ажил дээр өнгөрсөн хугацаанд яг нөгөө Солонгосын талд компани нь дампуураад алга болчихсон. Бодитойгоороо жишээлэхэд Өвөрхангай, Баянхонгор аймгийн станцууд хэзээ ашиглалтад орох вэ. Мэдээлэлтэй хүн байвал хариулж өгөөч гэж байгаа юм.

3 дугаарт нь дарга аа, цагаа нэмээд авчих уу.

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье.

Да.Цогтбаатар: 3 дугаарт нь нийслэл дээр жишээлэхэд 7 их наяд төгрөгийн алдагдал гарчихсан. Сангийн яам бол тэрийг өөрийгөө хүлээн зөвшөөрч байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч хүлээн зөвшөөрч байгаа. Энэ алдагдлыг энэ Төсвийн тухай хуультай хүртэл зөрчилдөөд эхэлчихсэн. Нийслэл өөрөө тайлбарлахаараа бид нар хуулийн дагуу ажилласан гэж байгаа юм. Энэ зөрчил алдаа дутагдлуудаа засаж орж ирэх үү, засаж чадах уу Сангийн сайд Мэндсайхан сайд гэсэн ийм 3 асуултдаа хариулт авах гэсэн юм.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ. Сангийн яам хариулна. Дэд сайд байна, Төрийн нарийн ч байна. Төрийн нарийн хариулъя. Индрийн микрофон шүү.

Б.Анар: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Анар. Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой эхний асуулт асуулаа гэж ойлголоо. Нийтдээ 5780 төсөвт байгууллага 670 төрийн өмчит үйлдвэрийн газар Эдийн засгийн байнгын хороо эхэлчихсэн. Сайд тэнд яг танилцуулга уншиж байгаа. Яах уу. Сайд байхгүй. 10 станц дээр Дэлгэржаргал хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр 10 аймгийн дулааны станцын хувьд бол Солонгосын Эксим банкны хөнгөлөлттэй зээл байгаа. Тэгээд өнгөрсөн жил бол яг гүйцэтгэгч нь дампуураад, шүүхийн маргаан үүссэн. Одоо ямар процесс явж байгаа вэ гэхээр ерөнхийдөө 3 хувилбараар саналаа бэлтгэж, Засгийн газрын тогтоол Эрчим хүчний яам оруулахаар бэлтгэж байгаа. Нийт 148 сая ам.доллараас 82 сая ам.доллар бол ашиглагдаагүй. Сангийн яамны хувьд ч гэсэн ер нь энэ зээлийг зогсоогоод улсын төсвөөр үргэлжлүүлэх саналыг гаргаж байгаа. Нөгөө талдаа яг Эксим банк талдаа бол энийг цаашаа үргэлжлүүлээд, ахиад нэмэлт санхүүжилтийн асуудал үүсэж байгаа учраас энэ бол маш хүндрэлтэй байдал руу орчхож байгаа. Гүйцэтгэгч шалгаруулах болон энэ бүх процесс Солонгосын хууль дүрмээр явсан учраас шүүхийн маргаан нь Солонгосын шүүх дээр үүсчихсэн явж байгаа.../минут дуусав/

Н.Наранбаатар: Хариултыг нэмье. Индрийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: Зээлийн хэлэлцээрийн хугацаа бол яг 2026 онд дуусаж байгаа. Дундаж гүйцэтгэл бол 9 аймаг дээр бол 45 хувьтай. Бид нарын яг Засгийн газар дээр ажиллаад, тооцоолол гаргаж байгаа хувилбар бол 2028 онд эхнээс нь дуусгах хувилбараар явж байгаа гэсэн үг. 2027, 2028 ондоо санхүүжүүлээд, 2028 онд дуусахаар.

Н.Наранбаатар: 2028 онд дуусах юм байна. 10-уулаа юу.

Ж.Дэлгэржаргал: Эхнээс нь ямар ч байсан үе шаттай дуусгана.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: 1 нам дангаараа хэт их хугацаанд буюу сүүлийн 10 жил засаг барихаар яаж дампуурдаг юм бодит жишээ энэ. Солонгосын талтай хамтарч байгаад 10 аймагт дулааны станц барина гэж төсөл хийгээд, Солонгосын компани нь яаж байгаад ч дампуурчихсан юм хэн мэдэх вэ. Зээлээ авсан хугацаа чинь дуусаж байхад бид нар гүйцэтгэл нь 45 хувьтай буюу тал төмөртэй л үлдэж байгаа юм. Төмөр каркастай. Тэгэхээр бид нар энэ улаан намын цагаан байрны дээрэмчидтэй чинь ямар нэгэн байдлаар хариуцлага тооцохгүй бол гараас нь ажил гарахаа больчихсоны тод жишээг сая Сангийн яам хариулж байгаа юм.

Тэгээд сүүлдээ төрийн нарийн нь өөрөө сайдынхаа эрхийг хэрэгжүүлнэ гээд зогсож байна шүү дээ. Сайдаас нь асуугаад байна. Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилоод, Ерөнхий сайд нь Засгийн газрын гишүүдээ томилоод, Засгийн газар нь өөрөө Төрийн нарийн бичгийн дарга нарыг томилж байгаа. Энэ 133 их наяд төгрөг дээр жишээлэхэд Төсвийн тухай хууль зөрчигдөөд байгааг засах эсэхийг нь л сайдаас асууж байгаа байхгүй юу.../минут дуусав/

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тэгээд сайдад хэлээрэй. Саяын асуултын хариуг бичгээр өгөөрэй.

Монгол Улсын 25 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон аудитын дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Түвшин гишүүнээр тасаллаа. Түвшин гишүүн.

Б.Түвшин: Хэдүүлээ 2025 онд зарцуулсан мөнгөнийхөө үр дүнг ингээд сонсож байгаа. Тэгээд Төсвийн байнгын хорооны гишүүд сонсож байгаа байдал энэ байна. Яах вэ, нэгэнт гараад дуусчихсан учраас хамаагүй гэж хандаж байж магадгүй л юм. Бодит байдал дээрээ бол яг энэ төлөвлөлтөөсөө илүү гүйцэтгэл дээрээ анхаарах ёстой. 1 тодотгол хийгээд бид нар анхны оруулж ирж байсан төслөөсөө бараг 90 гаруй хувийг нь зөвхөн урсгал зардалдаа зарцуулчихсан. Тэгээд төсвөө тодотгохоороо дараа нь хөрөнгө оруулалтынхаа зардлаас хасдаг. Ингээд нөгөө Оюутолгойн мөнгө ч гэдэг ч юм уу, Эрдэнэтийн мөнгө ч гэдэг ч юм уу Тавантолгойн мөнгөөр бүгдээрээ л урсгал зардлаа тэжээгээд, өдөр хоногоо өнгөрөөж байгаа. Энэ байнгын ажилтай хүмүүсийн функциональ тогтолцоо дээр яг тодорхой гаргах үр дүнгийн асуудал төдийлөн их яригдахгүй. Зүгээр чухам хэт их данхайсан байна, хэт их нүсэр байна уу гэдэг л асуудал яригддаг. Хөрөнгө оруулалт хийгээд юу бүтээхэв гэхээр 1 ширхэг ч юм байхгүй. Жилийн эцэс эхэнд төлөвлөгөө оруулж ирэхдээ орлогоо өндөр төлөвлөөд, зардлаа өндөр төлөвлөөд, тэгээд дээрээс нь эхлээд урсгал зардлуудаа гаргачихдаг. Урсгал зардлаа бол тасалж болдоггүй. Ингээд дараагийн тодотгол орж ирэхээр хөрөнгө оруулалтаасаа хасаад, буцаагаад нийт дүнгээрээ урсгал зардал 70, 80, 90 хувьтай явдаг. Тэгэхээр одоо ерөөсөө бид нарын цааш цаашдаа энэ төсвийн хөрөнгө оруулалтад хийх өөрчлөлтийн хамгийн том алхам бол урсгал зардлаа л бууруулах. Дээрээс нь энэ төсвийг тодотгодог асуудлыг болихгүй бол энэ тодотгол чинь өөрөө залилангийн шинж рүү явж байгаа байхгүй юу. Орлогоо албаар их тавиад, тэгээд хөрөнгө оруулалтаа хасаж оруулж ирдэг иймэрхүү л арга руу явчихлаа.

Тэгээд яг ийм байдлаар урсгал зардлыг санхүүжүүлээд өнгөрсөн 3, 4 жил шиг явж байгаа бол Монгол Улс хэзээ ч хөгжихгүй. Нөгөө уул уурхайн орлогууд чинь

бүгдээрээ урсгал зардал руу явж дуусаж байна. Цаашдаа ч ийм байна. Тийм учраас Сангийн сайдад яг шулуухандаа хэлэхэд дараа дараагийн төсвүүд дээр урсгал зардлыг эрс бууруулах шаардлагатай. Энэ ялангуяа уул уурхайгаас орж байгаа орлогууд дээр хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж, 2026, 2027, 2028 онд яг иймэрхүү эдийн засгийн өсөлт гарна гэдгийг л яг тодорхой төлөвлөхгүй бол урсгал зардал явсаар байгаад ингээд дуусаж байна гэдгийг л онцлон хэлье.

Тэгээд өнөөдрийн энэ төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байгаа асуудал ч гэсэн маш харамсалтай. Төсвийн байнгын хорооны гишүүд ч гэсэн хангалттай биш байна. Тэгээд ер нь цаашдаа бид нар энэ төсвийн гүйцэтгэл, төсвийн орлого, зардал дээрээ яг бүтцийн стракчер хийхгүй бол бүтцийн томоохон өөрчлөлт хийхгүй бол ер нь өдөр хоногоо өнгөрөөгөөд дуусаж байна гэдгийг та бүхэн ч өөрсдөө бас ойлгож байгаа байх. Яг энэ байдлаасаа бид нар бас хэлэлцэж байгаа асуудлыг ч гэсэн салгах хэрэгтэй. Ялангуяа энэ аудит дээр нэгтгэсэн тайлан биш төрийн өмчит компаниудын аудитын тайлангуудыг тусад нь сонсоод, дараа нь энэ төсвийн байгууллагуудыгаа сонсоод, тэгээд нэгтгэсэн тайлан дээр юу ярьдаг юм тэгээд процессын нэгтгэлийн асуудлаа л ярьдаг юм байгаа биз. Түүнээс биш ингээд нийлүүлээд нэгтгэсэн тайлан гээд ирчихээр үр ашгийн асуудал яригдахгүй. Үр дүнгийн асуудал яригдахгүй. Зүгээр л ийм хэт том тоо яриад, тэгээд тэр том тоондоо манараад ингээд хэдүүлээ ямар ч үр дүнгүй хэлэлцүүлэг болж дуусаж байна гэдгийг хэлье.

Тийм учраас аудит энэ дээр бас цаашаа анхаарах хэрэгтэй. Мэндээ сайд ерөөсөө яг шулуухандаа хэлэхэд урсгал зардлыг бууруулахгүйгээр манай Монгол Улс ер нь цаашдаа бүх орсон орлогоо урсгал зардалдаа зарцуулж байна шүү гэдгийг танд бас онцлон хэлье.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Баярлалаа. 2026 оны төсвийг батлахдаа 2025 онд жишээлэхэд бид нар бол 9 сарын 15-аас 11 сарын 15 болтол бүтэн 2 сар зөвхөн 34 их наяд төгрөгийг л тойрч хэлэлцсэн. 5 үе шатаар. Тэгээд төсөв батлахдаа 34 их наядыг 5 үе шатаар 2 сар хэлэлцэж байгаа юм бол төсвийн гүйцэтгэлийг буюу энэ 133 их наяд төгрөгийг яаж зарцуулсан бэ гэдэг өнгөрсөн жилийнхээ зарцуулалтын тайланг хэлэлцэхдээ 2 үе шатаар чуулган дээр 1 ярина, Байнгын хороон дээр 1 ярина. Ингээд дуусчхаж байгаа юм. Энийг илүү дэлгэрэнгүй ярьдаг болох ёстой гэдэг зарчмын шаардлага байсан учраас Дэгийн тухай хууль дээр өөрчлөлт оруулах гээд гишүүдийн асуулт асуух 5 үе шатаар ярихдаа нийт ярих хугацаа 3 минутаар 5 үе шат гэхээр 15 минутад хүрдэг юм. Тэгээд одоо энэ гүйцэтгэлээ ярихдаа бид бид нар бас бүх Байнгын хороод дээр 15 минутад холбогдох бүх асуултуудаа асуугаад аваадхаасай гэдэг үүднээс Дэгийн тухай хууль санаачилсан. Монгол Ардын нам энэ хуулийг хэлэлцүүлж, үр дүнд хүрээгүй буюу өнөөдрийн байдлаар бид нар ингээд төсвийн гүйцэтгэлээ 2 үе шатаар хэлэлцээд өнөөдрийн байдлаар ингээд маш богино хугацаанд яриад дуусаж байгаа юм гэдгийг бас хэлэх гэсэн юм.

Түрүүн нөгөө асуулт дээр бас цаг багтсангүй. Нийслэл дээр жишээлэхэд 2 хүнээс санал авангуутаа, нийслэлийн авто зам ашиглалтын татварыг нэмчихдэг юм. Тэгээд нийслэлийнхэн татварын, бондын юм уу энэ төсвөөр цугларч байгаа мөнгө нь нийлээд 28 их наяд төгрөг. Тэгээд үрэхээрээ яадаг вэ гэхээр төсөвт байгууллагуудын ТУЗ-д очиж 200 сая төгрөгийн урамшуулал авдаг, 15 туслах авч ажиллуулдаг. Дэлхийд багтахгүй хэмжээний бүр Монгол Улсын сайдаасаа их хэмжээний дарга нар болж мөнгийг нь үрж үзүүлдэг. Тэгэхээр нийслэл уг нь тэр

аваад байгаа их татвараа бууруулах уу гэдэг дээр бас хариулт өгчихвөл зүгээр байгаа юм. Иргэд зүгээр яг энийг хүсэж байгаа. Тэгээд хүсэлтэд нь та нар иргэдээ сонсож ажиллаж чадах уу л гэдгийг хариулж өгөөч гэж байгаа юм.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Түвшин гишүүний хэлж байгаа тэр урсгал зардлыг буулгах тал дээр илүү анхаараарай гэж санал нэг байгаа. Тэгэхдээ бид нар өөрсдөө хамт сууж байгаад баталж байгаа төсөв. Урсгал зардал дээр ер нь төсвийн реформын шинэчлэл хийхгүй бол бид нар чинь 200 гаруйгаар хуульчлаад өгчихсөн зардал байгаа юм. Тэгэхээр чинь бид нар төсвийн хүрээ баталдаг. Тэр хүрээндээ багтаагаад нөгөө хуульчилсан зардлуудаа шингээгээд явдаг. Тэгэхээр нөгөө талдаа хөрөнгө оруулалтын зардал руугаа ордог. Цогтбаатар гишүүн түрүүн бас асууж байна лээ. Төрийн өмчийн өр төлбөрийн асуудал байна гээд. Төрийн өмчийн асуудал дээр бол бид нар арга хэмжээ авна. Зүгээр өр төлбөрийг нь задлаад харах юм бол бас асуудлууд байна. Жишээ нь Эрдэнэс Монгол дээр гэхэд Тавантолгой дээр гэхэд тэр Эрдэнэс Монголын харьяа байгууллагуудын хоорондын өр өглөгүүд бүртгэгдчихсэн байна. Нөгөө талдаа урьдчилж орсон орлогууд байгаа шүү дээ. Нүүрсэн дээр гэхэд жишээ нь ороод ирчихсэн урьдчилаад авчихсан орлогууд байгаа. Энэ чинь баланс дээрээ өглөг талдаа бүртгэгдээд явж байгаа. Ямар хэлбэрээр хасагдаж байна гэхээр нөгөө нүүрсээ гаргах болгонд тэр нь хасагдаад явж байгаа. Тэгэхээр энэ нь бол балансын бүртгэл нь ингэж явж байгаа болохоос биш яг бодит өр төлбөрөө бас тооцоод үзвэл бол өөр дүн гарна. Ер нь зүгээр Засгийн газар дээр ажлын хэсэг байгуулсан. Бид нар төрийн өмчийн засаглалыг сайжруулах чиглэл дээр олон улсын зөвлөх үйлчилгээ авч ажиллая. Энэ цаашдаа бид нар энэ төрийн өмчит үйлдвэрүүдийг ашигтай ажиллуулах, хувьчлалд бэлтгэх үнэ цэнтэй болгож. Өнөөдөр байгаа төрийн өмчит үйлдвэрүүдийн чинь бараг нь ихэнх нь ашиггүй ажиллаад байна шүү дээ. Тэгэхээр ашигтай ажиллуулах, гол нь эрчим хүчний салбар алдагдалтай явж байна. Энэ салбарыг бид нар улсын төсвөөр татаасыг нь өгөөд явна гэдэг ойлголт бол байхгүй. Тэр энэ төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж, эндээс орох ашигт ажиллагааг нэмэгдүүлж байж бид нар бусад салбарын эрчим хүчний алдагдлыг хаах ч гэдэг юм уу. Энэ дээр бол Засгийн газар ажлын хэсэг гаргаад, хэлэлцүүлээд явж байгаа.

Нөгөө талдаа төсвийн хөрөнгө оруулалт талд ер нь энэ төрийн өмчийн компаниудын хөрөнгө оруулалт талд ч гэсэн Сангийн яаман дээр бид нар хууль бэлтгээд дуусаж байна. Намрын чуулганаар өргөн барина. Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг өргөн барина. Энэ асуудлыг ер нь бид нар авч үзэхгүй бол цаашдаа яг төсөв хэлэлцэх үед гишүүд төсвийн хэлэлцүүлгийн үед шинэ төсөв оруулж ирдэг ч юм уу, ажил, үйлчилгээ нэмнэ гээд. Эргээд энэ нь төсвийн сахилга бат талдаа бол асуудал болж хувираад байгаа юм.

Нийслэлийн тал дээр бол асуудал байна уу гэвэл байна. Нийслэл бол өнөөдөр бие даасан орлоготой. Энэ хэмжээгээрээ ер нь түрүүн тодотгох бол буруу гээд Түвшин гишүүн хэлж байна. Тодорхойгүй нөхцөл байдал үүсээд л бид нар тодотгоод байгаа юм. Түүнээс биш тодотгох их сайн учраас тодотгоод байгаа асуудал огт биш. Гэтэл бид нар тодотгохдоо бол зардлаа хасаад тооцоод, хамаг урсгал зардалдаа чөдөрлөгдөөд л яваад байгаа юм. Нийслэл зардлуудаа тэлээд явж байгаа. Тэгээд одоо юу гэдэг юм. Нийслэлийн энэ орлогын төсвийн сахилга батын хангалтгүй байдал чинь өөрөө улсын нэгдсэн төсөвт нөлөөлөөд байгаа байхгүй юу. Алдагдалд. Тэрийг ярихаар нийслэлийнхэн нийслэлийн төсөв алдагдалгүй байгаа. Их Хурал

бид нарыг алдагдалтай ярьж байна гээд төсвийн харилцаагаа ойлгохгүй яриад байгаа төлөөлөгч нар өнөөдөр иргэдийн Хурлын Төлөөлөгч нар төсөв батлаад суугаад байгаа юм.

Жишээлбэл, нийслэлийн төсөв алдагдалгүй батлагдах нэг өөр. Та нарын төсвийн хязгаарыг давж батлаад байгаа хөрөнгө оруулалт чинь өөрөө нэгдсэн төсвийн алдагдалд нөлөөлөөд байна гэдгийг ойлгоод, асуудлаа ярь. Улсын Их Хурлын гишүүд төсвийн харилцааны талаар ойлголцгүй та нарыг яриад сууж байгаа асуудал огт биш. Тийм учраас энэ асуудлыг бид нар эргэж харна. Ялангуяа 2027 оны төсөв бэлтгэхдээ бид нар нийслэлийн чиг үүрэг рүү юуг нь бүрэн шилжүүлэх вэ, ямар орлогуудыг нь бид нар татаж авах вэ, ямрыг нь үлдээх вэ гэдэг дээрээ бид нар намрын төсөв дээр бодлого болгож оруулж ирнэ. Өнөөдөр Засгийн газар дээр төсвийн хүрээний хязгаарыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт танилцуулсан. Энэ хүрээндээ бид нар шинэчлэлийн төсвийн реформыг хийх асуудлаа оруулж ирнэ.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Түвшин танилцуулна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

17.45 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ